

Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи ашиглан ЦЭХ-ийг
найдвартай, үр ашигтай дамжуулах нь бидний эрхэн зорилго мөн.



ДАМЖУУЛАХ

Сүлжээ



2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

№3 (163) 2025



“ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ” СОНИН - 20 ЖИЛ

“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”
ТӨХК-ийн түүхэн замнал, ололт амжилт, ажил амьдралын
хором бүрийг сонины хуудаснаа мөнхлөн үлдээх эрхэм
үүргээ нэр төртэй биелүүлсээр ирсэн “ДАМЖУУЛАХ
СҮЛЖЭЭ” сонины үе үеийн редакцын хамт олонд түүхт
20 жилийн ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Түүхийг дамжуулах сүлжээний ажилтнууд бүтээж,
түүнийг редакцын хамт олон хэвлэлийн хуудаснаа бичиж
мөнхлөдөг. Зуун дамжин, цаг үе улиран одохын хэрээр
тэрхүү хуудаснууд улам зузаарч, түүхийн гэрч болж

байдгаараа үнэ цэнтэй. Энэ л үүргийн жинхэнэ эзэн
болж, элч гэрлийг дамжуулагчдын түүхийг үлдээж буй
“ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ” сонины 20 жилийн ойн өдрийг
онцлоход таатай байна.

Хэдийгээр техникийн дэвшлийг даган хэвлэл мэдээллийн
салбар сүүлийн жилүүдэд цахимд идэвхтэй шилжиж буй ч
тогтмол хэвлэл сонин гэдэг эргээд түүх болж үлдэх учир
цэнээ хадгалж, хүндтэй байр суурийг эзэлсэн хэвээр байна.
“ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ” сонины замналын эхлэлийг
тавьж, анхны дугаараа 2005 оны аравдугаар сарын 01-

ний өдөр хэвлэн гаргасан тэр өдрөөс хойш эдүгээ хүртэл
тасралтгүй хэвлэгдэхдээ нийт 163 дугаарыг уншигчдадаа
өргөн барьжээ. Тэдгээр дугааруудын хуудас бүхэнд
Цахилгаан дамжуулах сүлжээний үйл ажиллагаа, ИТА,
мэргэжилтнүүдийн ажил үйлс, бахархам амжилтуудыг
гэрчлэн үлдээж, бүтээлцэж байгаад сонины редакцыг
хамт олонд 20 жилийн ойн баярын мэндийг хүргэе.

“ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ” СОНИН Түүхийн бичээс эх
сурвалж болж, хэдэн зууны дараа ч үнэ цэнтэй хэвээр байх
болно.

2025 ОНД ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДСАН ЭРХМҮҮД



“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОН”



Ахмад настан
Б.ЭНХБАТ



ЗӨБС-ын ахмад настан
Г.ЭРДЭНЭБААТАР



“АЛТАН ГАДАС
ОДОН”



Үйлдвэрчний эвлэлийн
хорооны дарга
Ц.МӨНХБААТАР



Реле хамгаалалт, туршилт
хэмжилтийн хэлтсийн дарга
Н.БАТБАЯР



УБС-ын Захиргаа, аж ахуйн албаны
ахлах бөгөөд дотоод ажил хариуцсан
мэргэжилтэн Т.АЮУШ



ТБС-ын Захиргаа, аж ахуйн
албаны дарга
Б.БАЯР



Зүүнхараа дэд станцын
Ашиглалтын инженер
А.БАТНАСАН



Сүхбаатар дэд станцын
Ашиглалтын инженер
Г.БАЯРАА



ТБС-ын цалин хөлсний
нягтлан бодогч
Б.БИЛГЭЭ



УБС-ын ахмад настан
М.ГАНБААТАР



ХБС-ын ахмад настан
Д.ДАШНЯМ



“ХӨДӨЛМӨРИЙН
ХҮНДЭТ МЕДАЛЬ”



Шуурхай зохицуулалтын
хэлтсийн дарга
Ж.ЧИНЗАЯА



Эдийн засаг, санхүүгийн
хэлтсийн ахлах эдийн засагч
Б.ГАНЦЭЦЭГ



ПХБ-ийн
төслийн монтер
Л.СОДОВСҮРЭН



УБС-ын Захиргаа, аж ахуйн
албаны хүний нөөцийн
мэргэжилтэн
Б.БОЛОРМАА



ЭРЧИМ ХҮЧНИЙ НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ШИНЭ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХЭРЭГЖИВ



төрийн өмчит компаниудын бүтцийг оновчтой тогтоож, засаглалыг сайжруулах, эрчим хүчний салбарын найдвартай ажиллагааг хангах зорилготой юм.

Тогтоолын дагуу “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн харьяанд Алтай-Улиастайн салбар болон Баруун бүсийн салбар шинээр байгуулагдлаа. Энэ нь бүс нутгийн эрчим хүчний найдвартай, тасралтгүй байдлыг хангах, хэрэглэгчдийг тогтвортой цахилгаанаар хангах чухал алхам юм.

Шинэ салбар байгуулсантай холбогдуулан 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр салбарын удирдлагуудыг томилсон бөгөөд Алтай-Улиастайн салбарын даргаар Бямбарагчаагийн Пүрэвренчин, Баруун бүсийн салбарын даргаар Гонгорын Заяабаяр нарыг тус тус томилжээ.

Монгол Улсын Засгийн газар “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын талаар авах зарим арга хэмжээний тухай” №30 дугаар тогтоолыг баталж, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК болон “Алтай-Улиастай эрчим хүчний систем” ТӨХК-ийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д нэгтгэх шийдвэрийг албан ёсоор баталгаажууллаа.

Энэхүү тогтоол нь 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар дэвшүүлсэн саналыг үндэслэн гарсан бөгөөд

Ч.АМАРСАНАА ДҮТ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛААР ТОМИЛОГДЛОО



Эрчим хүчний салбарт 26 жилийн турш тасралтгүй ажиллаж, салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан мэргэжлийн боловсон хүчин Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын хэлтсийн ахлах бөгөөд реле хамгаалалт, автоматикийн инженер Ч.Амарсанаа Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллахаар боллоо.

Тэрбээр, 1997-2001 онд УБЦШСГ-ын реле хамгаалалтын инженер, 2001-2011 онд ТБЦДС ТӨХК-ийн

реле хамгаалалтын ахлах инженер, дарга

2011-2013 ДҮТ ТӨХХК реле хамгаалалт, автоматикийн албаны дарга,

2013-2016 онд ЦДҮС ТӨХК-нд РХАХТХ-ийн дарга

2016-2025 онд ДҮТ ТӨХХК реле хамгаалалт, автоматикийн албаны дарга

2025-2026 онд ЦДҮС ТӨХК-ийн РХАХТХ-д удирдах албан тушаал хашиж, салбарын техник, технологийн шинэчлэл, найдвартай ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр болсон Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Ч.Амарсанааг гүйцэтгэх захирлаар албан ёсоор томилжээ.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн нийт хамт олон шинэ гүйцэтгэх захирлаар томилогдсон Ч.Амарсанаад ажлын өндөр амжилт хүсэн ерөөж байна.

МОНГОЛ, ОРОСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ БАЙГУУЛЛАГУУД ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛНЭ.

2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б. Дашдаваа, ерөнхий инженер Б. Эрхэмзаяа нар ОХУ-ын “Россети” нийгэмлэгийн Олон улсын хамтын ажиллагааны тусгай төлөөлөгч, ахлах зөвлөх Озган Кристина Константиновна, Олон улсын үйл ажиллагаа, олон нийтийн төслүүдийн газрын орлогч дарга Евсеев Алексей Павлович нарыг хүлээн авч, хамтарсан уулзалт зохион байгууллаа.

Уулзалтын үеэр талууд үйл ажиллагааны танилцуулга хийж, судалгаа хөгжлийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх санал солилцолцох, хуучирсан

тоног төхөөрөмжийн шинэчлэл, хүний нөөцийн сургалт, туршлага солилцох зэрэг цаашид хамтран ажиллах боломжуудыг тодорхойлсон үр дүнтэй уулзалт болов.

Мөн уулзалтаар

- улс хоорондын импортын ЦДАШ-уудын ашиглалтын түвшинг сайжруулах,
- 220 кВ-ын ЦДАШ-257, 258-ын РХАБ-ийг шинэчлэх,
- шинээр ЦДАШ барих техникийн бололцоог судлах,
- Баруун бүсийн 110 кВ-ын ЦДАШ С-458-ыг хоёр

хэлхээ болгон өргөтгөх,

- ОХУ-ын эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллах, тогтворжилтыг хангах чиглэлээр аваар эсэргүүцэх автоматикүүдийн ТЭЗҮ-г хамтран боловсруулах техникийн боломжийг судлах ажлын хэсэг байгуулсан нь Монгол, Оросын эрчим хүчний байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, техник, эдийн засгийн үндэслэл бүхий бодит төслүүдийг хамтран хэрэгжүүлэх чухал алхам боллоо.



МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ӨВӨР МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМТЭЙ ЗЭРЭГЦЭЭ АЖИЛЛАГААНД ЗАЛГАГДАХ БОЛОМЖ БҮРДЭЖ ГЭРЭЭ БАЙГУУЛАГДЛАА



Монгол Улсын эрчим хүчний систем Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-ны эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллагаанд залгагдан ажиллах 220 кВ-ын “Зэс Оюу” хуваарилах байгууламжийг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр техникийн комисс ажиллагаанд хүлээн авсан бол холбогдох талуудын төлөөлөл “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-нд гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагаа боллоо.

Энэхүү түүхэн үйл ажиллагаанд БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Эрчим хүчний групп” ХХК (ИМРС)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн дарга Жан Хайфэн, мөн орны “Эрчим хүчний Олон улсын хамтын ажиллагааны компани”-ийн (ИМРИС) ТУЗ-ийн дарга Ван Пэнфэй, Монгол Улсын эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Балжинням,

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Дашдаваа нар болон албаны бусад хүмүүс оролцов.

Тэртээ 1976 оны 12-р сарын 30-ны өдрийн 21:30 цагт Монгол Улсын эрчим хүчний систем ОХУ-ын эрчим хүчний системтэй холбогдон 50 орчим жилийн хугацаанд зэрэгцээ ажиллагаанд ажиллаж байгаа билээ.

Тэгвэл өнөөдөр дээрх гэрээнүүдэд гарын үсэг зурснаар ӨМӨЗО-ны эрчим хүчний системтэй холбогдон Өмнөд бүсийн зарим хэрэглээг хангах боломж бүрдлээ.

Энэхүү үйл явдал нь манай улс хөрш хоёр оронтойгоо эрчим хүчний салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд шинэ алхам болж улмаар нэгдсэн сүлжээний найдвартай, тогтвортой байдал дээшлэх давуу талтай юм.

ХБНГУ-ЫН ЗӨВЛӨХ DR.WENFRIED HEUSENGER-ТЭЙ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Монгол Улсын тогтвортой эрчим хүчний чадавхыг бэхжүүлэх” (CDSE) төслийн хүрээнд “Хосмог сургалт”-ыг хэрэгжүүлж байгаа “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн 110/35/10 кВ-ын Туул дэд станцын дэргэдэх “Өндрийн сургалтын төв”, Төвийн бүсийн салбарын дэргэдэх “Чадамжийн төв”-ийн үйл ажиллагаа болон мэргэжлийн боловсрол сургалтын Налайх политехникийн коллеж, Дархан политехникийн коллеж дээр ХБНГУ-ын зөвлөх Dr.Wenfried Heusinger 2025 оны есдүгээр сарын 16-19-ний өдрүүдэд уулзалт зохион байгууллаа. Уг уулзалтад Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн төслийн ахлах, мэргэжилтнүүд болон “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн холбогдох хэлтэс, салбарын инженерүүд, хосмог

сургалтад хамрагдаж буй суралцагчид, үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш нар өргөн хүрээтэй оролцож, хосмог сургалтын зохион байгуулалт, аж ахуйн нэгжийн хүний нөөц, сургалтын төлөвлөгөө, үнэлгээний арга зүй, хамтын ажиллагааны үйл явцыг танилцуулж, тулгарч буй хүндрэлтэй асуудал, асуултууддаа зөвлөгөө авлаа. ХБНГУ-ын зөвлөх Dr.Wenfried Heusinger нь хэлэхдээ мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, компанийн хамтын ажиллагаа, хүний нөөцийн чадавхжуулах үйл ажиллагааг сайн явагдаж байгааг онцолж, компани дээрх сургалтын хяналт үнэлгээг өөрийн загвар, аргачлалыг хэрэглэхийг санал болгож ХБНГУ болон бусад улсын туршлагын талаар зөвлөмж өгч санал солилцсон байна.



“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН 2025 ОНЫ ШИЛДЭГ 10 АЖИЛ



1 ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ: Германы сэргээн босголтын зээлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд дэд станцуудын тоноглол шинэчлэх барилга угсралтын ажил 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр эхэлж “Сүхбаатар”, “Налайх”, “Баянчандмань”, “Айраг”, “Хот”, “Бугант”, “Хялганат”, “Хөтөл”, “Баясгалант”, “Төв”, “Шарын гол”, “Баруунхараа”, “Бор-Өндөр”, “Үйлдвэр”, “Орхон”, “Хархорин”, “Булган” зэрэг 17 дэд станцын ажлыг бүрэн дуусгаж, 2026 онд үлдсэн 15 дэд станцын ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажил хангагдаад байна.



2 23ЭС-ОЮУ ДЭД СТАНЦЫН БАРИЛГА УГСРАЛТ: Монгол Улсад БНХАУ-аас Цахилгаан эрчим хүч импортлох, Төвийн бүсийн цахилгаан хангамжийг сайжруулах төслийн хүрээнд 220 кВ-ын Зэс-Оюу дэд станцын ил хуваарилах байгууламж болон 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлыг амжилттай дуусгаж, хүчдэл дор залгав.

3 АЛТАЙ-УЛИАСТАЙН САЛБАР БОЛОН БАРУУН БҮСИЙН САЛБАРЫГ БАЙГУУЛАВ: Эрчим хүчний найдвартай, тасралтгүй байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоолоор “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Алтай-Улиастайн салбар болон Баруун бүсийн салбарыг байгуулав.

4 2025-2035 ОНД НИЙСЛЭЛИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТ: Улаанбаатар хот орчмын 2035 он хүртэлх өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах төлөвлөлт боловсруулав. Тухайн ажлын хүрээнд 2025-2035 онд дамжуулах болон түгээх сүлжээнд шинээр барих шугам, дэд станцуудын хүчдлийн түвшин, чадал зэрэг техникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлж, одоогийн сүлжээнд холбох техникийн шийдлийг гаргах, байршил трасс сонгох, шаардагдах хөрөнгө зардлын урьдчилсан тооцоог хийх ажлуудыг гүйцэтгэсэн байна. Мөн цахилгаан хангамжийн төлөвлөлтөд орсон шинээр баригдах болон өргөтгөл шинэчлэл хийгдэх 13 дэд станцын зураг төслийн ажлыг хийх гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт явагдаж Дамбадаржаа, Богд дэд станцуудын барилга угсралтын ажил хийгдэж байна.

5 ТОСНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ, ӨНДӨР ХҮЧДЛИЙН ТУРШИЛТЫН ЛАБОРАТОРИ БАЙГУУЛАВ: Өндөр хүчдлийн тосны химийн лаборатори нь MNS ISO/IEC 17025:2018 стандартыг авснаар зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэж, лабораторийн шинжилгээний үр дүн нь үнэн зөв, албан ёсоор баталгаажих, дотоодын болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх боломж бүрдсэн.



6 ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА: ОХУ-ын “Россети” нийгэмлэгтэй хамтран улс хоорондын агаарын шугамын ашиглалтын түвшинг сайжруулах, 220 кВ-ын 257, 258 дугаар шугамын реле хамгаалалт автоматикийг шинэчлэх, Баруун бүсийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг хоёр хэлхээ болгон өргөтгөх, ОХУ-ын эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллах, тогтворжилтыг хангах зорилгоор аваар эсэргүүцэх автоматикуудын техник эдийн засгийн үзүүлэлтийг хамтран боловсруулах, техникийн боломжийг судлах асуудлаар ажлын хэсэг байгуулж, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, бодит төслүүдийг хамтран хэрэгжүүлэх чухал алхам боллоо.



8 ХОСМОГ СУРГАЛТ: “Монгол Улсын Тогтвортой Эрчим Хүчний чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд 110/35/10 кВ-ын Туул дэд станцыг түшиглэн өндрийн сургалтын төвийг нээлээ. Тус төвд “Өндөр хүчдэлийн техникч”-ийн хосмог сургалт явуулах, багш, дадлагажуулагчдын чадавхыг сайжруулах, бодит орчинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хэрэгжүүлэх, сэлгэн залгалт, өндөрт ажиллах дадлыг төлөвшүүлэх боломжтой юм.



7 ХЭМАБ-ЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЭВ: Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлэн олон улсын ISO 45001:2018 стандартын шаардлагад нийцүүлэн ажиллаж эхэллээ. Энэхүү тогтолцоо нь осол, эрсдэлийг системтэйгээр бууруулах, ажилтнуудын аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих үр дүнтэй шийдэл болж байна.

9 ЖАЙКА БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ, БАГАНУУР-ЧОЙРЫН ТӨСӨЛ: Японы олон улсын техникийн хамтын ажиллагааны байгууллага /JICA/ Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д 2 сая америк долларын өртөг бүхий явуулын гэмтэл оношилгооны төхөөрөмжийг буцалтгүй тусламж болгон хүлээлгэн өгөхөөр болов. Үүний үр дүнд алслагдсан дэд станц болон цахилгаан дамжуулах агаарын шугамд гарсан гэмтлийг оношилж илрүүлэх ажлыг хөнгөвчлөхийн зэрэгцээ төлөвлөгөөт үзлэг шалгалт явуулахад ахиц гарах юм. Мөн “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол улсын их хурлаас соёрхон баталж, 220 кВ-ын Багануур-Чойр цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийн санхүүжилтийн гэрээг байгуулан, олон улсын тендерийн баримт бичгийг боловсруулаад байна.

Мөн “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол улсын их хурлаас соёрхон баталж, 220 кВ-ын Багануур-Чойр ЦДАШ-ын төслийн санхүүжилтийн гэрээг байгуулан, олон улсын тендерийн баримт бичгийг боловсруулаад байна.



10 УЛААНБААТАР САЛБАРЫН БАРИЛГЫН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛИЙН АЖИЛ: УУлаанбаатар салбарын ажилчдын тав тухтай, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сургалт, лабораторийн зориулалттай шинэ барилгыг бүрэн ашиглалтад оруулж, ажилчдын сэтгэл ханамж, сургалтын чанар, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг бодитоор нэмэгдэх, урт хугацаанд тогтвортой хөгжлийг дэмжих суурь бүрдэв.





КОМПАНИЙН 2025 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН АВАРГУУД

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 2025 оноо үдэж, эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь байж ажил хөдөлмөрөөрөө хамт олноо манлайлсан хөдөлмөрийн аварга, тэргүүний ажилтнуудаа тодрууллаа.



Хөдөлмөрийн аварга
Удирдах албан тушаалтан
Ч.СУГИРТОГТОХ



Хөдөлмөрийн аварга-ИТА
Н.НАРАНБАЯР



Хөдөлмөрийн аварга
Ашиглалтын монтер
Э.ЭНХДОЛГОР



Хөдөлмөрийн аварга
Шуурхай ажиллагааны ИТА
С.САРАНГЭРЭЛ

АЖЛЫН БАЙРНЫ СОЁЛ-5С ХӨТӨЛБӨРИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН 2025 ОНЫ ШИЛДЭГ ДЭД СТАНЦУУД.



ТЭРГҮҮН БАЙР УЛААНБААТАР САЛБАРЫН 110/10/6 КВ-ЫН
“ӨМНӨД ДЭД СТАНЦ”



Хөдөлмөрийн аварга
Засварын монтер
Э.АМАРБАЯСГАЛАН



Хөдөлмөрийн аваргаалбан хаагч
Б.БАТЦЭЦЭГ



Хөдөлмөрийн аварга ажилтан
Д.БАТБОЛД

КОМПАНИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТНУУД



ДЭД БАЙР ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАРЫН 110/35/10 КВ-ЫН
“АЙРАГ ДЭД СТАНЦ”



Төв удирдлагын Тэргүүний ажилтан
Г.ОЮУНДЭЛГЭР



Улаанбаатар салбарын Тэргүүний ажилтан
Д.ТӨМӨР-ОЧИР



Хангайн бүсийн салбарын Тэргүүний ажилтан
Ц.БОЛДБААТАР



ГУРАВДУГААР БАЙР УЛААНБААТАР САЛБАРЫН 110/35/10 КВ-ЫН
“НАЛАЙХ ДЭД СТАНЦ”



Төвийн бүсийн салбарын Тэргүүний ажилтан
Н.СУГАРСҮРЭН



Зүүн-Өмнөд бүсийн салбарын Тэргүүний ажилтан
Н.УРАНТОГОС



Говийн бүсийн салбарын Тэргүүний ажилтан
Д.БАТСУУРЬ



Ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, оновчтой санал, бүтээлийг дэмжиж урамшуулах шинээр дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх зорилготой Тесла ба Эдисон уралдааныг 2020 оноос хойш зохион байгуулсан бөгөөд энэ жил уг уралдаанд дараах багууд шалгарсан байна.

“ТЕСЛА БА ЭДИСОН” УРАЛДААНЫ ШИЛДЭГҮҮД ТОДРОВ

“ШИЛДЭГ ТӨСӨЛ” ТӨРӨЛД



Нэгдүгээр байр

“Дамжуулах сүлжээнд нисдэг камер (дроне)-г ашиглах үр ашигтай санаанууд”-г боловсруулсан Улаанбаатар салбарын диспетчер инженер Р.Алдаржавхлан, Э.Хатанбаатар, Д.Чойжамц нар



Дэд байр

“220/110/35/10 кВ-ын Тавантолгой дэд станцын 3D модель ба 3D хэвлэлт” төслийн боловсруулсан Говийн бүсийн салбарын ээлжийн инженер Э.Анхбаяр, ээлжийн монтёр Ц.Хичээнгүй нар

“ШИЛДЭГ БҮТЭЭЛ” ТӨРӨЛД



Нэгдүгээр байр

Төвийн бүсийн нээгдсэн сүлжээний хоногийн ачааллыг хиймэл оюун ухааны алгоритм ашиглан таацлах бүтээлийг хийсэн Мэдээлэл технологийн хэлтсийн программист инженер А.Алтан-Очир, программын ашиглалтын инженер Б.Болормаа нар



Дэд байр

“дамартай утас болон кабель хөвөгч” бүтээлийг хийсэн Зүүн-Өмнөд бүсийн салбарын санаачлагч Реле хамгаалалт, автоматик, хэмжилт туршилтын албаны дарга Б.Мягмарсүрэн, Реле хамгаалалт, автоматик, хэмжилт туршилтын албаны инженер техникийн ажилтан нарын баг

“АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨРЧИЛГҮЙ АЖИЛЛАСАН ЦАГ” УРАЛДААНЫ ШИЛДЭГҮҮД



Техникийн албаны төрөл
Улаанбаатар салбарын Ашиглалт, шуурхай үйлчилгээний алба



Техникийн бус албаны төрөл
Зүүн-Өмнөд бүсийн салбарын Захиргаа, аж ахуйн алба



“ӨНДРИЙН СУРГАЛТЫН ТӨВ”-ИЙН АНХНЫ СЕРТИФИКАТ ОЛГОХ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ БОЛЛОО.

2025 оны наймдугаар сарын 27-28-ны өдрүүдэд “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-тэй хамтран 110/35/10 кВ-ын Туул дэд станцыг түшиглэн байгуулсан “Өндрийн сургалтын төв”-ийн анхны сертификат олгох сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Үйлдвэрлэлийн ослын статистик мэдээллээр өндрөөс унаж амиа алдах, хүнд болон хөнгөн гэмтэл авах тохиолдлууд хамгийн их бүртгэгддэг. Иймд ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх

зорилгоор энэхүү сургалтыг зохион байгуулсан нь онцлог байлаа.

Уг сургалтаар өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа, арга техник, сэргийлэх, хамгаалах, тусламж үзүүлэх дадлага зэрэг сэдвүүдийг хамарсан онолын болон практик хичээлүүд явагдаж нийт 14 суралцагч сертификат гардан авсан юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын энэхүү сургалт нь салбарын ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэхэд бодит хувь нэмэр оруулж байна.



ТАРИФ МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ЛАВЛАХ ЖИШИГ БАРИМТ БИЧГИЙГ ШИНЭЭР БОЛОВСРУУЛАН БАТЛУУЛЛАА.

Сургалт бүтээмж, хамтын ажиллагааны хэлтэс нь компанийн хэмжээнд ажлын байрны тодорхойлолтын үндсэн зорилт, сургах, мэргэшүүлэх хөтөлбөрийг чанаржуулах, ажилтны ажлын гүйцэтгэлийн түвшинг үнэлж дүгнэх зорилтын хүрээнд дор дурдсан мэргэжлийн нийт 30 нэр төрлийн тариф мэргэшлийн зэргийн лавлах жишиг баримт бичгийг шинээр боловсруулан батлууллаа.

Үүнд:

1. Шугамын засварын монтер
2. Дэд станцын засварын монтер
3. Реле хамгаалалт, автоматикийн монтер
4. Өндөр хүчдэлийн туршилт, хэмжилтийн монтер
5. Ээлжийн монтер
6. Өндөр үелзлэлийн холбооны монтер



АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАГДАЖ, ТӨЛӨВЛӨГӨӨ БАТАЛЛАА

“Эрчим хүчний салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах /2023-2032/ стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зорилгоор” “Цахилгаан Дамжуулах Үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны зургаадугаар сарын 20-ны өдрийн А/113 дугаар тушаалаар компанийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хэсэг

байгуулагдан ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд 2025 оны долдугаар сарын 08-ны өдөр компанийн нийт ажилтнууд дунд “Жендэрийн тэгш эрхийг хангахад олон талт оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан юм.



ПАМИРЫН НОЁН ОРГИЛД ЛЕНИНД МОНГОЛ УЛСЫН ДАЛБААГ МАНДУУЛЛАА.



Дашрамд дурдахад түүний дараагийн том зогсоол зорилго нь дэлхийн хамгийн өндөр цэг болох далайн түвшнээс дээш 8848 метрийн өндөрт оршдог “Эверест” хэмээв. Зориг, тэвчээр, авхаалж самбаа шаардсан спортоор хичээллэдэг

Р.Алдаржавхланд ажилд нь өндөр амжилт хүсэж, олон олон өндөр оргилуудад мөрөө гаргахыг хүсье.

Улаанбаатар салбарын Ашиглалт шуурхай үйлчилгээний албаны диспетчер инженер Р. Алдаржавхлан нь ОУХМ С.Ганхүүгээр удирдуулан 2025 оны зургаадугаар сарын 27-оос долоодугаар сарын 15-ны хооронд Киргиз, Тажикстан улсуудын нутагт орших алдарт Памирын нуруу, Тянь-Шань ууланд авиралт хийж Ленин оргил (далайн түвшнээс дээш 7143 м) өндөрт авирч Монгол улсын далбааг мандуулжээ.

Тэрбээр 2018 оноос хойш уулын аврилтаар хичээллэж эхэлсэн бөгөөд “Өндөр уулын спорт”-ын нэгдүгээр зэрэгтэй авирагч юм. Р.Алдаржавхлан нь Ленин оргилын аврилтаар спортын мастерын болзлоо хангасан бөгөөд ирэх оноос Уулын улсын аварга буюу 2 жилд нэг болдог “Альпина” дээр спортын мастерын хамгаалах аврилтаа хийх төлөвлөгөөтэй байгаа аж.



ШИНЭЭР 110/35/10 КВ-Н 2 ДЭД СТАНЦ АШИГЛАЛТАД ОРЛОО

Улаанбаатар салбарын харьяанд 2х25 MBA чадалтай Бараат дэд станц 2025 оны есдүгээр сарын 06-нд ашиглалтад орсон бол 2х16 MBA чадалтай Хилэм дэд станц 2025 оны есдүгээр сарын 16-ны өдөр байнгын ашиглалтанд орж, ажиллагаанд залгагдлаа.

Бараат дэд станц нь 110/35/10 кВ-н Хөшигт дэд станцаас 110 кВ-н Бараат-А, Б АШ-р тэжээгддэг бөгөөд 110 кВ-н тоноглол нь гадаа суурилуулах GIS буюу PASS системээр тоноглогдсон дамжуулах сүлжээний анхны дэд станц юм. Бараат дэд станц ашиглалтанд орсноор 35 кВ-н Төв аймаг-А,Б АШ-г шинээр залгаж, Яармаг болон Ташгай дэд станцуудаас тэжээгддэг 35 кВ-н Зуунмод-А,Б АШ-н ачааллыг

хувааж, аймгийн төвийн хэрэглэгчдийг найдвартай эрчим хүчээр хангах шинэ схемийн боломж үүслээ.

Хилэм дэд станц нь 220/110/35 кВ-н Сонгино дэд станцаас 110 кВ-н Хилэм-А,Б АШ-р тэжээгдэн ажилладаг ба Улаанбаатар хотын баруун бүсийн шинэ цэвэр усны эх үүсвэрийн тэжээлийн төслийн ажлын хүрээнд ашиглалтанд орсон юм. Хилэм дэд станц ашиглалтанд орсноор шинээр 35 кВ-н Шувуу-А,Б АШ залгагдаж, УБЦТС-ний 35/6 кВ-н Шувуу дэд станцыг хэрэглээг бүрэн тэжээж ажиллаж байна. Ингэснээр 35 кВ-н Сонгино-А,Б, Харцага-А,Б АШ-н ачааллуудыг хөнгөлж, Шувуу дэд станц 2 талын тэжээлийн эх үүсвэртэй болж, схем найдваржив.

ЖЕНДЕР

ЖЕНДЭРИЙН АНХАН ШАТНЫ ОЙЛГОЛТ ӨГӨХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ.

Эрчим хүчний салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратеги төлөвлөгөө /2023-2032 он/, жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөө-нд тусгасаны дагуу салбарын үйлдвэр компаниудын инженер техникийн ажилтан, албан хаагч нарт жендэрийн анхан шатны ойлголт өгөх сургалтыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК дээр зохион байгууллаа.

Сургалтыг жендэрийн үндэсний хорооны сурлагч багш Б.Амгалантуяа, Г.Гүнжлхам нар удирдан явуулж, Хүйс ба жендэрийн

ялгаа, хэвмэл ойлголт болон Эрчим хүчний салбар дахь жендэрийн эрх тэгш байдал өнөөгийн тулгамдаж буй асуудлуудын талаар өргөн хүрээний мэдээлэл өгсөн сургалт болж, төв удирдлагын 41 ажилтан танхимаар, орон нутгийн 265 ажилтан цахимаар хамрагдав.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь жендэрийн тэгш байдал болон ёс зүйн хариуцлагатай байгууллагын соёлыг төлөвшүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлэн ажиллах болно.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛД ГҮРЖИЙН ТУРШЛАГААС СУРАЛЦЛАА.



Зах зээлийн шилжилтийн стратеги боловсруулах сургалт Тбилисид амжилттай боллоо.

Эдийн засаг санхүүгийн хэлтсийн ахлах бөгөөд эдийн засагч Б.Ганцэцэг нь Азийн хөгжлийн банк болон Эрчим хүчний яамтай хамтран хэрэгжүүлж буй зах зээлийн шилжилтийн стратеги, төлөвлөгөө боловсруулах, салбарын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх хүрээнд Гүрж улсад туршлага судаллаа.

2025 оны есдүгээр сарын 21-29-ний өдрүүдэд Гүрж улсын Тбилиси хотод зохион байгуулагдсан сургалтад УИХ-аас томилогдсон Эрчим хүчний хуулийн төслийн баг, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Улаанбаатарын цахилгаан түгээх компанийн төлөөлөл хамтран оролцсон юм. Энэхүү сургалт нь Гүрж улсын Эдийн засаг тогтвортой хөгжлийн яам (ЭЗТХЯ), Үндэсний зохицуулах хороо, Цахилгаан эрчим хүчний зах зээлийн оператор, Эрчим хүчний бирж, Түгээх компани, Цахилгаан систем оператор компанийн (Дамжуулах) үйл ажиллагаатай танилцаж Гүрж улсын туршлагыг гүнзгийрүүлэн судлах чухал боломж байлаа.

Гүрж улсын эрчим хүчний салбарын бүтэц, бодлого Гүрж улс нь 69,700 км² нутаг дэвсгэртэй, 3.7 сая орчим хүн амтай, Зүүн Европ ба Баруун Азийн заагт оршдог. Цаг агаарын хувьд далайн уур амьсгалтай чийглэг, өндөр уулархаг бүс нутагт сэрүүн байдаг.

Гүржийн Эдийн засаг тогтвортой хөгжлийн яам (ЭЗТХЯ) нь эрчим хүчний бодлого, реформ, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр гурван албатай. Тус яам нь хууль, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлж, салбарын

стратеги боловсруулан, хөрөнгө оруулалт татах, өрсөлдөөнт зах зээлийг хөгжүүлэх үүрэгтэй.

Эрчим хүчний системийн хүчин чадал, үзүүлэлтүүд 2024 оны байдлаар Гүржийн эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 4,671 МВт бөгөөд үүнд:

Усан цахилгаан станц – 3,460 МВт

Дулааны цахилгаан станц – 1,190 МВт

Салхины цахилгаан станц – 20.7 МВт

Цахилгаан эрчим хүчний үзүүлэлт:

үйлдвэрлэл-14,234 сая кВт.цаг,

дотоодын хэрэглээ 14,414 сая кВт.цаг,

импорт 1,228 сая кВт.цаг,

экспорт 1,047 сая кВт.цаг

Гүрж улсын цахилгаан систем (дамжуулах) (Georgian State electrosystem (GSE))

Гүрж улсын Дамжуулах системийн оператор (Georgian State Electrosystem (GSE)) нь төрийн өмчит компани нь цахилгаан эрчим хүчний системийн тогтвортой байдал, аюулгүй ажиллагааг хангах үндсэн үүрэгтэй. 6,498км урт 220/110/35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 500/220/110/35 кВ-ын дэд станцуудын эзэмшдэг.

GSE нь жил бүр сүлжээний хөгжлийн арван жилийн төлөвлөгөөг боловсруулан Үндэсний зохицуулах хороонд танилцуулдаг. Төлөвлөгөөнд эрэлт, нийлүүлэлтийн таамаглал, хил дамнасан шилжүүлэг, хөрөнгө оруулалтын хуваарь, шинэ байгууламжуудын мэдээлэл багтдаг.

Гүржийн үндэсний зохицуулах хороо (GNERC Georgian National Energy and Water Regulatory Commission)

Зохицуулалтын бие даасан тогтолцоо Гүржийн Үндэсний эрчим хүч, усны зохицуулах хороо (GNERC) нь цахилгаан эрчим хүч, байгалийн хий, усан хангамжийн үйлчилгээ зэрэг дэд бүтцийн салбарт тусгай зөвшөөрөл олгож, зах зээлийн хяналт, маргаан шийдвэрлэх үүрэгтэй. Хороо нь төрийн шууд хяналтаас ангид, бие даасан хуулийн этгээдийн статустайгаар үйл ажиллагаа явуулдаг.

Сургалтын явцад Монголын төлөөлөгчид Гүржийн эрчим хүчний зах зээлийн оператор, эрчим хүчний бирж, түгээх компани, цахилгаан системийн операторын үйл ажиллагаатай танилцаж, зах зээлийн шилжилтийн стратеги боловсруулахад шаардлагатай мэдлэг, туршлагыг хуримтлуулсан нь Монголын эрчим хүчний салбарын шинэчлэлд үнэтэй хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

А/182 ТУШААЛААР БАРАА МАТЕРИАЛЫГ НЭГДСЭН НЭРШИЛД ХӨРВҮҮЛЭН МӨРДӨН АЖИЛЛАХААР БОЛОВ.

Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд мөрдөх үндсэн зарчмын хүрээнд хөрөнгийн бүртгэлийг эмх цэгцтэй байлгах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдөр “Бараа материалын нэршлийг нэгдсэн нэршилд хөрвүүлэх тухай” А/182 дугаар тушаалыг боловсруулан батлуулж, салбаруудад хүргүүлсэн.

Салбарын санхүүгийн ажилтнууд тушаалд заасан бараа материалын нэгдсэн жагсаалтын дагуу бүртгэж, цаашид мөрдөн ажиллана.

БАРАА МАТЕРИАЛЫН НЭГДСЭН НЭРШЛИЙН ЖАГСААЛТ

Шугамын тоноглол	
Сэлбэг, материалын нэр	Тип марк /Ор
Төмөр тулгуур	У100-2+14
Төмөр тулгуур	У100-2+9
Төмөр тулгуур	У110-2+5
Төмөр тулгуур	У110-2Т
Төмөр тулгуур	У110-2+14
Төмөр тулгуур	У110-1
Төмөр тулгуур	У220-2+9
Төмөр тулгуур	У220-2т+9
Төмөр тулгуур	У220-2т
Төмөр тулгуур	У220-2+5
Төмөр тулгуур	У220-2т+5
Төмөр тулгуур	У220-1
Төмөр тулгуур	У220-2
Засварын төмөр тулгуур	ПС220-2т
Засварын төмөр тулгуур	ПС220-2
Засварын төмөр тулгуур	П220-2
Засварын төмөр тулгуур	П220-2Т+5
Засварын төмөр тулгуур	П220-2т

Мэдээ бэлтгэсэн: Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн ахлах бөгөөд эдийн засагч Б.Ганцэцэг

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ХЭЛТЭС

MICROSOFT TEAMS
ПРОГРАМЫН ТАНИЛЦУУЛГА

Microsoft Teams нь Microsoft 365-ийн нэг хэсэг бөгөөд Skype for Business болон Microsoft Classroom-г халж гарч ирсэн.

Энэ видео хурлын дуудлага хийх, чат бичих, файл хуваалцах, багийн ажлыг удирдах зэрэг олон боломжийг санал болгодог харилцаа холбооны орчин үеийн платформ юм.

2025 оны байдлаар Microsoft Teams нь дэлхий даяар сар бүр 360 сая идэвхтэй хэрэглэгчтэй болж, өсөлтөө тогтмол хадгалж байна. Энэ нь видео хурлын зах зээлийн 32 хувийг эзэлж, өдөр бүр 2.7 тэрбум минутын уулзалт хийгдэж байгаа нь Teams-ийн хэрэглээний цар хүрээг илтгэх тоон үзүүлэлт юм.

Fortune 100 компанийн 93% нь өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдаг. Teams-ийн гол давуу тал нь харилцаа холбоо, хурал уулзалт, файл хуваалцах, хамтын ажиллагааг нэг дор төвлөрүүлж, мэйлийн хэрэглээг бууруулан

ажлын урсгалыг хялбарчлах явдал юм. Үүний үр дүнд байгууллагуудын бүтээмж өсөж, ажилтнуудын оролцоо нэмэгдэн, зардал буурч, инновац хөгжих боломж бүрдэж байна.

Манай компанийн хувьд мэдээллийн аюулгүй байдал нэн чухал зорилтын нэг бөгөөд бид 2025 оны зургаадугаар сарын 1-нээс эхлэн харилцаа холбооны платформ Telegram-г халж Microsoft Teams руу шилжүүлсэн.

Компаний хэмжээнд ашиглалтын судалгаа

Компанийн хэмжээнд Microsoft Teams

программыг нэвтрүүлж эхлэснээс хойш компьютер дээрээс 32%, Вебээс 10%, iPhone утаснаас 32%, Андроид утаснаас 26%-тайгаар суулгаж ашигласан байна. Сүүлийн 90 өдрийн статистик мэдээллээс дүгнэхэд компанийн хэмжээнд **106,772** чат мессеж илгээгдэж, **336** хурал болж, **58,337** минут (**973** цаг) аудио яриа өрнөж **49,502** минут (**825** цаг) видео хурал болсон байна.

MICROSOFT 365 АШИГЛАСНЫ
ДАВУУ ТАЛУУД

Бид Microsoft 365-ын standard болон premium багцыг цөөн тооны лицензийг авч ашиглаж байгаа билээ.

Microsoft 365 нь бидний хэрэглэж дадсан (Word, Excel, PowerPoint зэрэг) программуудын desktop болон онлайн хувилбарыг багтаахаас гадна бусад программууд хоорондоо саадгүй уялдаа холбоотой ажиллах боломжтойгоороо онцлог юм.

OneDrive: Хэрэглэгч бүрд олгогддог 1 терабайт хадгаламжийн эрхийг ашигласнаар, бүх баримт бичгийг үүлэн орчинд найдвартай хадгалж, физик дискийн эвдрэл, төхөөрөмжийн гэмтлээс үүдэх мэдээлэл алдагдах эрсдэлийг бүрэн арилгах боломжтой.

SharePoint-ийн тусламжтайгаар багийн болон төслийн түвшний хамтарсан ажлын талбар үүсгэж, олон хэрэглэгч нэгэн зэрэг Word, Excel баримт дээр хамтран ажиллах боломж бүрдсэн.

Цаашид бид Microsoft 365-ын дараах боломжуудыг сурталчлан таниулснаар компанийн үр ашгийг дээшлүүлэх боломжтой гэж харж байна.

Exchange Online үйлчилгээг компанийн албан ёсны transco.mn домайн хаягтай холбосноор, standart license-тэй хэрэглэгч бүр 50 GB хэмжээтэй бизнесийн түвшний имэйл хайрцаг (mailbox) ашиглах боломжтой.

Microsoft Forms хэрэгслийг ашиглан байгууллагын хэмжээнд санал асуулга, мэдээлэл цуглуулалт, мөн ААД-ын ээлжит шалгалтыг цахим хэлбэрээр хурдан

бөгөөд үр дүнтэй авч, үр дүнг нэгтгэн дүгнэх боломжтой болсон.

Power automate: 365 доторх аппуудыг хооронд нь холбож, ажлын урсгалаа хялбархан автоматжуулах боломжтой.

Саяхан бид Дүнжингарав, Хүрхрээ, Буянт-Ухаа зэрэг байршлуудад SCADA удирдлагын системийн нэвтрүүлэлтийг амжилттай өргөжүүлсэн. Эдгээр байршлуудыг системд нэмснээр эрчим хүчний хяналт, удирдлагын цар хүрээ улам бүр өргөжин, илүү өргөн хүрээнд автоматжуулалтыг хэрэгжүүлэх боломжтой боллоо.

SCADA СИСТЕМИЙН ТУХАЙ

Бид Дүнжингарав, Хүрхрээ, Буянт-Ухаа байршлуудад SCADA удирдлагын системийн технологийн сүлжээнд амжилттай холбон өргөжүүлсэн. Эдгээр байршлуудыг системд нэмснээр эрчим хүчний хяналт, удирдлагын цар хүрээ улам

бүр өргөжин, илүү өргөн хүрээнд автоматжуулалтыг хэрэгжүүлэх боломжтой болж байна.

SCADA (Supervisory Control and Data Acquisition) системийг бүрэн нэвтрүүлснээр эрчим хүчний системд өндөр түвшний автоматжуулалт бий болох боломжтой. Энэхүү систем нь дараах онцлог, давуу талуудыг санал болгодог.

Бодит Хугацааны Хяналт: Бүх төрлийн реле болон хэмжих хэрэгслүүдээс бодит хугацааны өгөгдлийг цуглуулж, хяналт тавих боломжтой.

Визуал Хяналт: График хэрэглэгчийн интерфэйс болон динамик зураглалын тусламжтайгаар үйл явцыг визуал байдлаар бүрэн хянах боломжтой.

Алсын Удирдлага: Алсын удирдлага болон хяналтын функцуудыг ашиглан үйлдлүүдийг шуурхай, үр дүнтэй гүйцэтгэнэ.

Аналитик ба Тайлагнал: Цуглуулсан өгөгдлийг боловсруулж, дэвшилтэт аналитик болон түүхэн тайлан гаргах чадвартай.

Алдааны Урьдчилан Сэргийлэлт: Автомат дохиолол болон түгшүүрийн сэрэмжлүүлгийн систем нь болзошгүй алдааг илрүүлж, урьдчилан сэргийлэхэд тусална.

Интеграцын Чадвар: Логик удирдлага болон автоматжуулалтын системүүд (PLC, DCS)-тэй нэгдсэн байдлаар ажиллаж, процессын удирдлагыг сайжруулна.

Эрчим Хүчний Хэмнэлт: Эрчим хүчний хэрэглээг хянах, хэмнэлтийн

шинжилгээ хийх боломжийг бүрдүүлнэ.

Аюулгүй Байдал: Хэрэглэгчийн эрхийн шатлалтай хяналт болон олон улсын нууцлалын стандартад нийцсэн систем нь мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

Нийцтэй Байдал: OPC UA, IEC 61850 зэрэг орчин үеийн протоколуудтай нийцэж, бусад системтэй саадгүй холбогдон, төвлөрсөн удирдлагын тогтолцоог бий болгоно.

Мэдээ бэлтгэсэн: Мэдээлэл технологийн хэлтсийн програмист инженер А.Алтан-Очир

ГЭМТЛИЙГ ИЛРҮҮЛЖ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЛАА

110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцын Т-2 трансформаторыг хэмжилт туршилтын үр дүнг үндэслэн гэмтлийг илрүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа.

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн Засвар зохицуулалтын хэлтсийн тосны химийн лабораторийн 2025 оны төлөвлөгөөт ажлын хүрээнд Улаанбаатар салбарын 110/10/6 кВ Өмнөд дэд станцын Т2 трансформаторын тосонд физик химийн шинжилгээ хийж гүйцэтгэсэн.

Энэхүү шинжилгээ нь трансформаторын тосны усны агуулга, хүчлийн тоо, цахилгаан даац, механик хольц, тосонд ууссан хийн үзүүлэлтүүдийг олон улсын MNS ISO, ASTM стандартуудын дагуу тодорхойлж, тосны чанар, аюулгүй ажиллагаа, тоноглолын найдвартай байдалд үнэлэлт өгөх зорилготой юм.

Шинжилгээний үр дүнд тосны чанар нь стандарт шаардлагад нийцэхгүй болох нь тогтоогдсон бөгөөд уг трансформаторыг БНХАУ-д үйлдвэрлэгдсэн хэсэгчилсэн цахилгалт тодорхойлох багажаар хэмжилт хийхэд засварлах шаардлагатай гэсэн үр дүн гарснаар трансформаторыг задалж, гэмтлийг илрүүлсэн.

Гэмтэл нь зүрхэвчид гажилт үүссэний улмаас хэсэгчилсэн цахилгалт үүсэж, ороомгийн даравч хэсэгт тосны тортог үүсэх нөхцөл бүрджээ. Тус гэмтлийг үндэслэн 2026 онд 110/10/6 кВ Өмнөд дэд станцын Т-2 трансформаторын засварын ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Трансформаторын тосны чанарыг тодорхойлох шинжилгээ гүйцэтгэснээр гэмтлийг эрт илрүүлж, урьдчилан



оношилгооны үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.

Энэхүү арга хэмжээ нь цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг хангахад чухал ач холбогдолтой бөгөөд ирээдүйд тоноглолын чанар, аюулгүй ажиллагааг сайжруулахад чухал туршлага болж үлдлээ.



ТЕХНИКИЙН ӨНДӨР НАРИЙВЧЛАЛТАЙ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛАН БИД ТОНОГЛОЛЫН ЭВДРЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ, ХЭВИЙН АЖИЛЛАГААГ ХАНГАХЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЖ БАЙНА.

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн химийн лаборатори

нь 2008 оноос хойш үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж, шаардлагатай тоног төхөөрөмжийг өндөр нарийвчлалын хэмжих хэрэгслээр материалын хэрэгцээг тодорхойлж худалдан авалтуудыг гүйцэтгэж, тоног төхөөрөмжийн нөөцийг хангаж ажиллаж байгаа.

Өмнөх дугаарт бид тосны химийн лабораторийн шинжилгээг хийдэг багаж байдаг гэдгийг танилцуулсан бол энэ удаа дэлгэрэнгүй танилцуулга хийхээр бэлдсэн юм.


1. BAUR DPA -75 С маркийн нэвт цохилтын хүчдэл тодорхойлох багаж



2. Кристалл-2000 М маркийн хийн хроматографийн багаж



3. Тосны хүчлийн тоо тодорхойлогч Coulometer-KOH маркийн багаж



4. Тосны механик хольц тодорхойлогч MICOM- P маркийн багаж



5. Тосны тангенс дельта тодорхойлогч HJZD-22 маркийн багаж



6. Тосны зуурамтгай чанар тодорхойлогч HZYN-1301 маркийн багаж



7. Coulometer-WTD маркийн усны агууламж тодорхойлох багаж



Мэдээ бэлтгэсэн: Засвар зохицуулалтын хэлтсийн Тосний химийн лабораторын эрхлэгч Б.Мөнгөнжин

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

“ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ” ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

Төслийн барилга угсралтын ажилд ашиглагдах 110 кВ-ын элегаз таслуур, 110 кВ-ын гүйдлийн трансформатор, 35 кВ-ын вакум таслуур, 35 кВ-ын гүйдлийн трансформатор, 220 кВ-ын хүчдэлийн трансформатор, 110 кВ-ын хүчдэлийн трансформатор бүхий анхдагч хэлхээний нийт 665ш тоноглол, трансформаторын удирдлага, хамгаалалтын панель, төв дохиоллын самбар, трансформаторын цуглуулгын самбар, 35 кВ-ын таслуурын цуглуулгын хайрцаг, 35 кВ-ын АШ-ын удирдлага хамгаалалтын панель бүхий хоёрдогч хэлхээний тоноглолууд болон удирдлага, хүчний, газардуулгын кабелиуд гадаад улсаас нийлүүлэгдсэнийг гаалийн татвар, НӨАТ-аас чөлөөлүүлэх хүсэлтийг Эрчим хүчний яам, Сангийн яам, Гаалийн ерөнхий газарт хандаж гарган шийдвэрлүүлж холбогдох татваруудаас чөлөөлүүлэх ажлыг зохион байгуулсан.

•Төслийн Гүйцэтгэгч MCS Интернэйшнл ХХК нь дэд станцуудын шинэчлэлийн ажлуудыг Улаанбаатар, Төв, Хангай, Зүүн-Өмнөд гэсэн 4 бүсэд хуваан төслийн талбайд барилга угсралтын ажлыг зэрэгцээ гүйцэтгэх 6 бригадыг гарган ажиллаж байна.

•Төслийн шинэчлэлийн ажил 2025 оны зургаадугаар сарын 07-ны өдөр 110/35/6 кВ-ын “Сүхбаатар” дэд станцаас эхэлсэн бөгөөд есдүгээр сарын 05-ны өдрийн байдлаар дараах дэд станцуудын

110, 35 кВ-ын таслуурууд, гүйдлийн трансформаторууд, реле хамгаалалт, автоматикийн байгууламжийг шинэчлэх ажлыг бүрэн гүйцэтгэж хүчдэлд залгасан. Үүнд:

1. 110/35/6 кВ-ын “Сүхбаатар” дэд станц
2. 110/35/10 кВ-ын “Налайх” дэд станц
3. 110/35/10 кВ-ын “Баянчандмань” дэд станц
4. 110/35/10 кВ-ын “Айраг” дэд станц
5. 110/6 кВ-ын “Хот” дэд станц
6. 110/35/6 кВ-ын “Бугант” дэд станц
7. 110/10 кВ-ын “Хялганат” дэд станц
8. 110/35/6 кВ-ын “Хөтөл” дэд станц
9. 110/35/6 кВ-ын “Баясгалант” дэд станц

• Барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу дараах дэд станцуудад үргэлжлэн хийгдэж байна.

1. 110/6 кВ-ын “Төв” дэд станц
2. 110/6 кВ-ын “Шарын гол” дэд станц
3. 110/35/10 кВ-ын “Хархорин” дэд станц
4. 110/35/10 кВ-ын “Булган” дэд станц
5. 110/35/6 кВ-ын “Бор-Өндөр” дэд станц
6. 110/35/10 кВ-ын “Баруунхараа” дэд станц

Шинэчлэл хийгдсэн дэд станцуудын барилга угсралтын явцын зургууд:



Бугант-110 кВ-ын таслуур



ТБС-т буусан тоноглол хадгалалт

Мэдээ бэлтгэсэн: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ахлах инженер Т.Цэвэгсүрэн

ISO 45001:2018 СТАНДАРТЫГ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар нь “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийг олон улсын жишигт нийцсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо ISO 45001:2018 стандартын шаардлагуудыг амжилттай хэрэгжүүлсэнд тооцож 2025 оны наймдугаар



сарын 5-ны өдөр уг стандартыг нэвтрүүлснийг нотлох гэрчилгээг олголоо.

Энэхүү стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор тус компани 2024 оны гуравдугаар сараас эхлэн стандартын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Обзерв консалтинг” ХХК-тай хамтран ажиллаж, Төв удирдлага болон Улаанбаатар салбарын хэмжээнд тогтолцоог нэвтрүүлэх ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлсэн юм.

Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн ISO 45001:2018 стандарт нь байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог тогтвортой хэрэгжүүлж, ажилтан, ажил олгогчийн эрүүл, аюулгүй орчныг хангахад чухал ач холбогдолтой.

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК нь энэхүү стандартыг нэвтрүүлснээр байгууллагынхаа ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг дээшлүүлэх, эрсдэлийг удирдах тогтолцоог тасралтгүй сайжруулах, олон улсын шаардлагад нийцсэн менежментийн шинэ түвшинд хүрсэн чухал алхмыг хийлээ.

2028 оны зургаадугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд хүчинтэй бөгөөд энэ хугацаанд байгууллага стандартын хэрэгжилтийг тасралтгүй сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, олон улсын шаардлагад нийцүүлэн ажиллах үүрэг хүлээж байна.

АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАСНЫ СТАНДАРТ ШИНЭЧЛЭХ НЬ

Компанийн гүйцэтгэх захирлын А/109 дугаар тушаалаар “Ажлын тусгай хувцасны стандарт шинэчлэх ажлын хэсэг” байгуулагдаж, ажилтнуудын аюулгүй байдал, тав тух, байгууллагын дүр төрхийг сайжруулах зорилгоор шинэ стандартыг боловсруулжээ.

Судалгаанд нийт 715 ажилтан оролцсон бөгөөд “Ногоон + Цэнхэр” өнгөний хослол хамгийн олон санал авсан байна. Мөн ажилтнуудын дундаж өндөр, жин, размерын үзүүлэлтийг гаргаж, шинэ загварт тусгасан нь хувцасны тааруулалт, тав тухыг



Ажлын хэсэг нь хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг, судалгааны үр дүнд үндэслэн хувцасны I, II, III ангиллыг оновчтой тодорхойлж, материалын шаардлагыг олон улсын MNS ISO 13688:2000, IEC 61482-2, EN 20471, EN 1149-5 зэрэг стандарттай нийцүүлэн шинэчилсэн байна. Ингэснээр цахилгаан нум, механик нөлөөлөл, гэрэл ойлголт, антистатик хамгаалалтын шаардлагыг бүрэн хангах боломжтой болжээ.

нэмэгдүүлэхэд чиглэжээ. Шинэ стандарт нь зөвхөн техникийн шаардлага хангасан байх төдийгүй ажилтнуудын санал, хэрэгцээнд тулгуурласан загвар, өнгө, хийцийн шийдлүүдийг багтаасан нь онцлог юм. Одоогоор уг стандарт нь захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэх шатандаа явж байгаа бөгөөд батлагдсаны дараа албан ёсоор хэрэгжиж эхлэх юм.

Мэдээ бэлтгэсэн: Хяналт мониторингийн хэлтсийн ХАБЭАИ Г.Оюундэлгэр, Б.Батжаргал

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК нь гамшгийн үед ажиллах чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журам болон аюулгүй ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, Гүйцэтгэх захирлын тушаалаар баталлаа.

Шинэчилсэн журам нь: Хүн хүч, тусгай зориулалтын машин механизмын байршлыг оновчтой зохион байгуулах; Ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох; Аюулгүй ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэх; Гамшгийн үед шуурхай хариу арга хэмжээ авах чадавхыг нэмэгдүүлэх зорилготой юм. Энэхүү шинэчлэл нь компанийн гамшгийн эрсдэлийг бууруулах, ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад чухал алхам болж байна.



РЕЛЕ ХАМГААЛАЛТ, ХЭМЖИЛТ, ТҮРШИЛТЫН ХЭЛТЭС

БНСУ-ЫН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНТЭЙ ТАНИЛЦСАН НЬ

Стандарт хэмжил зүйн газар болон БНСУ-ын Стандарт хэмжил зүй, судалгаа шинжилгээний хүрээлэн /KRISS-ийн хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Дэежон хотод 2025 оны есдүгээр сарын 07-18-ний өдрүүдэд цахилгаан ба цахилгаан соронзон хэмжилт, ISO/IEC:17025 Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторид тавигдах ерөнхий шаардлага, хувьсах ба тогтмол гүйдэл, хүчдэлийн шалгалт тохируулга сэдэвт сургалтад зохион байгуулсан. Уг сургалтад Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын хэлтсийн лабораторийн эрхлэгч Ж.Хосбаяр нь хамрагдаж туршлага судалсан.

Тухайн сургалтаар хэмжил зүйн үйл ажиллагаанд программ хангамжыг хэрхэн ашиглах, эталон тоног төхөөрөмжүүдийн шалгалт тохируулгын стандартууд, эталон тоног төхөөрөмжийн нэгж дамжуулалтыг хэрхэн хийж гүйцэтгэх талаар суралцсан байна. БНСУ-ын Стандарт хэмжил зүй, судалгаа шинжилгээний хүрээлэн нь хэмжил зүйн чадавхаараа Азидаа тэргүүлдэг бөгөөд тус сургалтад Тайланд, Энэтхэг, Тайвань, Гонконг, Индонез, Узбекистан, Балба, Саудын Араб, Гүрж, Уганда улсын хэмжил зүйн хүрээлэнгийн цахилгаан хэмжүүрийн лабораторийн мэргэжилтнүүд хамрагдсан өргөн хэмжээний сургалт болсон юм.



Мэдээ бэлтгэсэн: Реле хамгаалалт, автоматик, хэмжилт, туршилтын хэлтсийн лабораторын эрхлэгч Ж.Хосбаяр

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР 15 АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭН БАТАЛЛАА

2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр компанийн хурлын танхимд Үйлдвэрлэл, техникийн зөвлөлийн ээлжит хуралдаан зохион байгуулагдаж, нийт 15 асуудлыг хэлэлцэн баталлаа. Хурлаар компанийн дэд станцуудын горим, схемийн найдвартай байдал, тоноглолын шинэчлэл, хүчин чадлын зохицуулалт зэрэг техникийн чухал асуудлуудыг авч хэлэлцсэн бөгөөд дараах шийдвэрүүдийг гаргасан юм. Үүнд:

-“110/10 кВ-ын Хялганат дэд станцын 110 кВ талд ХТ суурилуулах, зураг, шийдэл хэлэлцүүлэх асуудал”-ыг хэлэлцэж, 110 кВ-ын ЦДАШ-ын алдагдлыг тооцох баланс тооцоонд шаардлагатай байгаа 110 кВ-ын ХТ-ыг суурилуулах, өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан схемийг зураг төслийн шатанд зөвшилцөж, схемийн хувилбаруудыг судалж газар дээр нь дахин хэмжилт хийх,

-“110/35/10 кВ-ын Булган дэд станцын 110 кВ-ын Булган А, Б ЦДАШ-ын РХА-ийг бэлтгэл хамгаалалтын релетэй болгох асуудал”-ыг дэмжих. KFW банкны төслийн шинэчлэлтийн ажил хийгдэж дууссаны дараа 220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын 200 МВА АТ-1, 2-ын 110 кВ-ын бэлтгэл хамгаалалтын SEL-311C релег 110/35/10 кВ-ын Булган дэд станцын 110 кВ-ын Булган-А, Б АШ-ын бэлтгэл хамгаалалтад суурилуулж, шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг,

- 220 кВ-ын 215, 216-р ЦДАШ-ын аянгын троссыг шилэн кабель бүхий аянгын троссоор шинэчлэх ажил”-ыг хэлэлцэж, Говийн бүсэд хил залгаа эрчим хүчний системийн сүлжээ үүсгэхэд онцгой ач холбогдолтойг онцолж, төсвийг дахин нягтлах, шалгах ажлыг зохион байгуулах,

Шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг хэлтсийн дарга, салбарын ерөнхий инженерүүдэд үүрэг болгов.

Д/д	Холболтын цэг	Суурилагдсан чадал	Байрлал
1	220/110/35 кВ-ын Мандал дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламж	50 МВт, 200 МВт*цаг багтаамжтай батерей хуримтлуурын станц	Дундговь аймаг, Сайнцагаан сум
2	220/110/35 кВ-ын Багануур дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламж	50 МВт, 200 МВт*цаг багтаамжтай батерей хуримтлуурын станц	Багануур дүүрэг
3	110/10 кВ-ын Хөшигт дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламж	50 МВт-ын суурилагдсан чадалтай нарны цахилгаан станц	Төв аймаг, Сэргэлэн сум
4	220/110/35 кВ-ын Оюутолгой дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламж	50 МВт-ын суурилагдсан чадалтай салхин цахилгаан станц	Өмнөговь аймаг, Баян-Овоо сум
5	220 кВ-ын Зэс-Оюу хуваарилах байгууламжийн 220 кВ-ын ил хуваарилах байгууламж	180 МВт-ын суурилагдсан чадалтай салхин цахилгаан станц	Өмнөговь аймаг, Цогтүзний сум
6	110/35 кВ-ын Багахангай дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламж	60 МВт суурилагдсан чадалтай Дулааны цахилгаан станц	Багахангай дүүрэг
7	220/220 кВ-ын Цагаан-суварга дэд станцын 220 кВ-ын ил хуваарилах байгууламж	100 МВт суурилагдсан чадалтай Дулааны цахилгаан станц	Дорноговь аймаг, Мандах сум

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2025 онд 434 техникийн нөхцөлийн хүсэлт ирснээс 168 хүсэлт баталгаажиж төвийн бүсийн эрчим хүчний системээс нийт чадал 25 МВт-ын ачаалал 2026-2027 онд холбогдох нөхцөлтэйгөөр олгогдоод байна.

Сэргээгдэх эрчим хүчний 4 эх үүсвэрийн 310 МВт, Батерей хуримтлуурын 2 эх үүсвэр 100 МВт, Багахангай дүүрэгт шинээр дулаан цахилгаан станцын 60 МВт, Дорноговь аймгийн Мандах суманд шинээр 100 МВт цахилгаан станц барих техникийн нөхцөлүүд Эрчим хүчний

яамны техникийн нөхцөл олгох ажлын хэсгээр дэмжигдээд байна. Хөвсгөл аймгийн өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангах ажлын хүрээнд 110/35/6 кВ-ын 3х6,3 МВА чадалтай Мөрөн дэд станцыг 110/35/10 кВ-ын хүчдэлийн түвшинд шилжүүлж, 2х25 МВА суурилагдсан чадалтай дэд станц болгох өргөтгөлийн техникийн нөхцөл батлагдаж, зураг төсөл боловсруулах ажлыг Хөвсгөл аймгийн Засаг Даргын Тамгын Газарын захиалгаар нээлттэй тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж зураг төслийн ажил эхлүүлээд байна.

ЦДАШ-ЫН ТАСРАЛТ СААТЛЫГ БУУРУУЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨЛЛИЙГ СУДАЛЖ БАЙНА

Компанийн хэмжээнд цахилгаан дамжуулах агаарын шугамуудын тасралт саатлыг бууруулах техникийн өнөөгийн байдалд магадлал хийх, судалгаа шинжилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах ажлыг компанийн хэмжээнд хэрэгжүүлж байна.

Энэхүү судалгааг ЭХЭЗХ, УЦУОСМХ-ний цаг уур судлаач Доктор Д. Дуламсүрэн нарын багтай хамтран гүйцэтгэж байгаа бөгөөд олон жилийн насжилттай, тасралт их гардаг 110 кВ-ын Хархорин А, Б болон Бор-Өндөр чиглэлийн ЦДАШ-уудыг сонгон авч, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн

гамшигт үзэгдлийн нөлөөллийг нарийвчлан шинжилж байна.

Судалгаагаар Булган–Хархорин чиглэлд өвлийн улиралд огцом хүйтрэлт ажиглагдаж, хур тунадас 11%-иар нэмэгдсэн бол Чойр–Бор–Өндөр чиглэлд хаврын улиралд дулааралт хамгийн их явагдаж, хур тунадас улирлаар харилцан адилгүй өөрчлөгдөж байна.

Уур амьсгалын дулааралт нь газрын гүнд тод илрэх болсноор цэвдэг хайлж, тулгуур баганууд хөдөлгөөнд орон суурийн тогтвортой байдал алдагдан

хүчтэй салхи шуурганд унах эрсдэлийг нэмэгдүүлэх болсон. Мөн цас, салхины ачаалал, хур тунадас, температурын эрс тэс өөрчлөлтүүдийг харгалзан цахилгаан шугамын утас, суурь, дамжуулах байгууламжийн бүтцийг сайжруулах, бат бөх байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Энэхүү судалгааны хүрээнд тооцоолсон шинэчилсэн стандартуудыг техникийн баримт бичигт тусган, цахилгаан шугам, дамжуулах сүлжээ, эрчим хүчний хангамжийн системд зориулсан шинэ

нөхцөлд тэсвэртэй материал болон технологиудыг нэвтрүүлэх болсныг харуулж байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь ирээдүйд цахилгаан сүлжээний үйл ажиллагаанд илүү их сорилт, ачааллыг авчрах нь тодорхой. Тиймээс, цахилгаан сүлжээнд шаардлагатай шинэчлэлтүүдийг хурдацтай хэрэгжүүлэх, инновацын шийдлүүдийг ашиглах нь цахилгаан эрчим хүчний аюулгүй байдал болон хэрэглэгчдийн аюулгүй байдалд үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой.

ШУУРХАЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭС

CS11-0448:2020 СТАНДАРТЫГ МӨРДЛӨГ БОЛГОН АЖИЛЛАХ НЬ

“ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ НЭРШИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА” буюу Байгууллагын стандарт CS11-0448:2020-ийг өдөр тутмын шуурхай ажиллагаанд мөрдлөгө болгон ажиллаж байна.

“Шуурхай зохицуулалтын хэлтэс” болон “Техникийн бодлогын хэлтсийн” инженерүүдийн хамтран боловсруулсан энэхүү нэршлийн стандарт нь “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны гуравдугаар сарын 31-ний өдрийн А/132 тоот тушаалаар батлагдаж, мөн оны дөрөвдүгээр сарын 01-ний өдрөөс компанийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ стандартад нэгдсэн сүлжээний дүрмийн шуурхай ажиллагааны нэршлийн талаар ойлгомжгүй байгаа зарим зүйл заалтыг тодорхой болгон компанийн хэмжээнд ижил төрлийн схем, үүрэг зориулалттай тоноглолын шуурхай ажиллагааны нэршлийг нэг загварт /маягт/ оруулах, шинээр ашиглалтад орж байгаа болон өргөтгөл шинэчлэл хийгдэж байгаа шугам, дэд станцуудын шуурхай ажиллагааны нэршлийг оноох, нэршлийн болон шуурхай ажиллагааны схем, нэгдсэн схем, сэлгэн залгалтын үлгэрчилсэн программ боловсруулах, батлуулах зэрэгт үндсэн суурь хүч болгон ашиглаж байна.

Стандарт хэрэгжиж эхэлснээс хойш өнгөрсөн 5 жилийн хугацаанд компанийн хэмжээний 85 дэд станцын тоноглолын шуурхай ажиллагааны нэршлийг нэг загварт оруулж, сэлгэн залгалтын үлгэрчилсэн программыг боловсруулан батлуулсан ба ТБНС-ний хэмжээнд шинээр ашиглалтад

орж байгаа цахилгаан байгууламжийн шуурхай ажиллагааны схем, нэршил, сэлгэн залгалтын программ зэрэгт арга зүйн зөвлөмж болгон ашиглаж байна.

Тухайн стандартад цахилгаан байгууламжийн тоноглолд хэрхэн нэр өгөх, хаяг хийх, нэршлийг товчлох, газар дээр нь байрлуулах талаар нарийн тодорхой /хавсралт хэлбэрээр/ схемийн хамт тусгасан байгаа нь шуурхай ажиллагаанд ашиглахад хялбар болсон байна.

220/110/35 КВ-Н ОЮУТОЛГОЙ ДЭД СТАНЦЫН 35 КВ-Н ИЛ ХУВААРИЛАХ БАЙГУУЛАМЖИД СХЕМИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙГДЛЭЭ.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэрэглээ өсөн нэмэгдэж, 35/10 кВ-н Ханбогд дэд станцад шинээр 2х10 МВА чадалтай трансформатор суурилуулж өргөтгөлийн ажил хийгдсэнтэй холбоотойгоор 35 кВ-н Ханбогд-А, Б АШ шинээр баригдаж, 220/110/35 кВ-н Оюутолгой дэд станцын 35 кВ-н ил хуваарилах байгууламжийн I, II секц шинийн цуваа схемийг зэрэгцээ болгон өөрчиллөө. Ингэснээр 35 кВ-н хос хэлхээ бүхий ЦДАШ-г дэд станцын шинтэй холбоход хялбар болж, Ханбогд сумын цахилгаан хангамжийн найдваржилт дээшилсэн ба хуучин Ханбогд АШ-аар Баян-Овоо сумыг тусад нь тэжээх схемийн хувилбарт шилжүүлээ.

110/35/6 КВ-Н СҮХБААТАР ДЭД СТАНЦЫН ӨРГӨТГӨЛ ШИНЭЧЛЭЛИЙН АЖИЛ АМЖИЛТТАЙ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн төслийн ажлын хүрээнд Сүхбаатар дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлж 2х25 МВА-н хүчний трансформатор, 110 кВ-н I ба II систем шин, 110 кВ-н Сүхбаатар АШ болон Т-1, 2-н

холболтын тоноглол шинээр суурилуулах ажил хийгдэж байна. KFW болон Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн төслийн ажил бүрэн дууссанаар 2х10 МВА чадал бүхий трансформатор, түүний холболтын 110 кВ-н ОД, КЗ тоноглол бүрэн шинэчлэгдэж элсгэз таслуур, гүйдлийн трансформатор, хуурай салгуур, микропроцессорын реле хамгаалалтын тоноглолоор солигдож, схемийн болоод тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа дээшлэх давуу тал үүсэж байна.

80МВТ/200МВТ.Ц “СОНГИНО” БХС-ААС ДЦС-4 ТӨХК-ИЙН 4-Р БЛОКИЙГ “0” ЗОГСОЛТООС СЭРГЭЭХ BLACK START ТУРШИЛТЫН ЭХНИЙ ҮЕ ШАТУУД АМЖИЛТТАЙ БОЛЛОО.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд “0” зогсолт үүссэн үед Сонгино БХС-аас ДЦС-4-н сэргээх боломжийн дагуу ДЦҮС, ДҮТ, ДЦС-4, ЭХСАТЧХ-н төслийн нэгж зэрэг байгууллагуудын хамтарсан баг ерөнхий төлөвлөгөөг гаргаж, компанийн шуурхай зохицуулалтын хэлтсээс туршилтын сэлгэн залгалтын хөтөлбөрийг боловсруулж ажиллаа. Туршилтын ажлын хүрээнд наймдугаар сарын 07-ны өдөр 220/110/35 кВ-н Сонгино дэд станцын 220/110 кВ-н I систем шин болон АТ-1-г хүчдэлээс бүрэн чөлөөлж, Сонгино БХС-аас туршилтын хүчдэл өгч, дотоод хэрэгцээний цахилгаан ачааллыг тэжээхэд 220 кВ-н хүчдэлийг 213 кВ, 110 кВ-н хүчдэлийг 111 кВ-оор тогтвортой барьж ажиллав. Туршилтын дараагийн үе шатуудад ИХБ-4-н 220 кВ-н I СШ-г хүчдэлээс чөлөөлж, 211-р АШ-р дамжуулан туршилтын хүчдэл өгч ДЦС-4-н 4Т трансформатораар дотоод хэрэгцээг сэргээж, ТГ-4-г ажиллагаанд оруулах ажлууд хийгдэх төлөвлөгөөтэй байна.

2025-2026 ОНЫ ӨВЛИЙН ИХ АЧААЛЛЫН ГОРИМ БОЛОН ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРОХ ЭХ ҮҮСВЭРИЙН ТАЛААР

ТБНС-ний 2025-2026 оны өвлийн их ачааллын горимд ЦЭХ-ний хэрэглээг түгээлтээр 6,892.2 сая кВт.ц буюу 2024-2025 оны өвлийн горимын гүйцэтгэлээс 6.8%-ийн өсөлттэй байхаар төлөвлөж ажиллаж байна. ДҮТ ТӨХХК-с хийсэн горимын тооцоог үндэслэн өвлийн горимын үеийн системийн оргил ачаалал 12 дугаар сард 1800 МВт, бага ачаалал 9 дүгээр сард 870 МВт байхаар төлөвлөгдсөн. Оргил ачааллын үед ДЦС-уудын үйлдвэрлэх хамгийн дээд чадал 1354 МВт, Батерей хуримтлуурын станцууд 148 МВт, ОХУ-с импортоор -300 МВт хүртэл ЦЭХ авахаар тооцсон байна. 2025-2026 оны өвлийн их ачааллын горимд Бөөрөлжүүтийн ЦС-н 150 МВт хүчин чадал бүхий 2-р блокын барилга угсралтын ажил дуусаж, арванхоёр дугаар сарын 15-ны дотор шинээр ашиглалтад орохоор төлөвлөгдөн ажиллаж байгаа ба Өвөр Монголын эрчим хүчний системээс 80 МВт хүртэлх ЦЭХ импортоор авах ажлын хүрээнд 220 кВ-н Зэс-Оюу хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажил дуусаж, хүчдэлд залгахад бэлэн болоод байна.

220 кВ-н Зэс-Оюу хуваарилах байгууламж нь 219, 220-р ЦДАШ-аар 220/110/35 кВ-н Оюутолгой дэд станц, 259, 260-р ЦДАШ-аар ӨМЭХС-ийн Гуо Хе дэд станц, 249, 250-р ЦДАШ-р Оюу толгой ХХК-ний Төв /Централ/ дэд станцуудтай холбогдон ажиллах схемийн зохион байгуулалттай юм.

Мэдээ бэлтгэсэн: Шуурхай зохицуулалтын хэлтсийн ахлах бөгөөд диспетчер инженер Ж.Хонгор
Мэдээ бэлтгэсэн: Шуурхай зохицуулалтын хэлтсийн ахлах бөгөөд диспетчер инженер Ж.Хонгор

“СУДАЛГАА, ХӨГЖИЛ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн дэргэдэх Судалгаа, хөгжил, төлөвлөлтийн хэлтэс нь 2025 оны 2 дугаар сард байгуулагдсан бөгөөд эрчим хүчний салбарын тогтвортой, найдвартай хөгжлийг хангах чиг үүрэгтэй нэгж юм.

Хэлтэс нь эрчим хүчний урт хугацааны төлөвлөлт боловсруулж баталгаажуулах, шинэ дэд станц, дамжуулах шугамын барилга байгууламжийг төлөвлөн

хэрэгжүүлэх, сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төслүүдийг техник, эдийн засгийн үндэслэлтэйгээр боловсруулах зэрэг үндсэн ажлыг гүйцэтгэдэг.

Мөн сэргээгдэх эрчим хүч, ухаалаг сүлжээ, эрчим хүч хадгалах технологийн судалгаа, дижитал шилжилтийн шийдлүүдийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Олон улсын туршлага, стандартыг судлан нутагшуулах, дотоодын болон гадаадын их дээд сургууль, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах нь тус хэлтсийн чухал чиглэлүүдийн нэг билээ.

Тус хэлтэс нь зөвхөн өнөөдрийн бус ирээдүйн эрчим хүчний хэрэгцээг хангах, хэрэглэгчдийн хүлээлтэд нийцсэн найдвартай цахилгаан дамжуулах үндэсний сүлжээг бий болгоход хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Уг ажлын түүчээ болгож ЭХЯ, Нийслэлийн засаг даргын тамгын газар, УБЦТС ТӨХК-тай хамтарч Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн төлөвлөлт-2035-ыг боловсруулсан.

ARCGIS ПРОГРАММЫН АНХАН ШАТНЫ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн зургийн инженерүүд болон программ хангамжийн 17 инженерүүдэд “ArcGIS орон зайн өгөгдлийн анхан шатны сургалт”-ыг 2025 оны зургаадугаар сарын 12-13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

ArcGIS гэж юу вэ?

ArcGIS нь газарзүйн байршлын мэдээлэлд суурилсан зураглал, орон зайн дүн шинжилгээ, өгөгдөл боловсруулах олон улсын түвшний программ хангамж юм.


Энэ программын тусламжтайгаар цахилгаан дамжуулах шугамын трасс төлөвлөх, дэд станц, тулгуурын байршлыг зураглах, объектуудын орон зайн өгөгдлийг үүсгэх, бодит байршлыг Google Earth дээр давхцуулан харах, цаашдын өөрчлөлт, засваруудыг тэмдэглэн удирдах, ирээдүйн төлөвлөлттэй давхцаж байгаа эсэхийг хянах зэрэг олон төрлийн ажлыг гүйцэтгэх боломжтой.

Тухайн сургалтад сууснаар

- Вектор өгөгдөл үүсгэх, засварлах
- Shapefile болон kmz/kml форматтай өгөгдөл дээр ажиллах
- Шинж чанарын мэдээлэл оруулах, удирдах
- Газрын зураг дээрх байршилтай бодит цагийн давхцал хийх
- Төлөвлөлтийн зөрчил, давхцал илрүүлэх арга зүй зэрэг анхан шатны практик ур чадваруудыг эзэмшсэн юм.

Сургалтыг Урчуудын Гантөмөрийн Пэрлиймаа удирдан явуулсан бөгөөд тэрээр Монгол Улсын Их Сургуулийн Газарзүйн тэнхимийн түр багш, “Гамшиг, гал түймрээс хамгаалах Монголын нийгэмлэг” ТББ-ын GIS мэргэжилтэн билээ.

Энэхүү сургалт нь инженерүүдийн GIS-т суурилсан орон зайн өгөгдлийн хэрэглээний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын байран дээрх шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



БҮС НУТГИЙН ХӨГЖИЛД ХҮЧ НЭМЭХ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМЫН ТӨСЛҮҮД УРАГШИЛЖ БАЙНА

Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд бүс нутгийн цахилгаан хангамжийг сайжруулах стратегийн төслүүд эрчимтэй хэрэгжиж байна.

Үүнд “Багануур–Чойр” болон “Мандалговь–Арвайхээр” чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ), дэд станцын төслүүд онцгой ач холбогдолтой.

Нэг. Багануур-Чойрын чиглэлийн 220 кВ-ын 188 км урттай 2 хэлхээт ЦДАШ, 220/110/35 кВ-ын “Чойр” дэд станц барих төсөл:

Монгол Улсын экспорт, импортын гол бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлтийн урсгал төвлөрдөг Өмнөговь, Дорноговь аймгийн бүс нутгийг найдвартай, хоёр талын тэжээлтэй цахилгаан хангамжтай болгох стратегийн зорилго бүхий Багануур–Чойр чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ) болон “Багануур”, “Чойр” дэд станцын өргөтгөлийн төсөл хэрэгжиж эхэлжээ.

Тус төсөл нь Монгол Улсын эрчим хүчний системийг тойрог схемтэй болгож, бүс нутгийн цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг сайжруулахад

чиглэж байна. Төслийн хүрээнд 188 км урттай, хоёр хэлхээт ЦДАШ, 220/110/35 кВ-ын хүчин чадалтай дэд станцуудыг барьж байгуулах бөгөөд Дорноговь, Дундговь, Хэнтий, Өмнөговь, Говьсүмбэр, Багануур, Сүхбаатар зэрэг аймгийн нийт 355,640 хэрэглэгчийн цахилгаан хангамжийн чанар, тогтвортой байдал эрс сайжрах юм. Шинэ шугам баригдсанаар “Багануур–Чойр–Айраг–Сайншанд–Замын-Үүд” чиглэлийн 110 кВ-ын шугамын тасралт, засварын үед үүсдэг эрчим хүчний хязгаарлалт арилж, хэрэглэгчид тасралтгүй цахилгаан хангамжтай болох нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн тус бүс нутагт төвлөрсөн томоохон ашигт малтмалын ордуудын цахилгаан хэрэглээ 500–600 МВт хүрэх төлөвтэй байгаа бөгөөд одоогийн 207-р шугамын хүчин чадал хүрэлцэхгүй байгаа тул АС-400 маркийн утастай шинэ шугам нь энэ хэрэгцээг хангахын зэрэгцээ “Бөөрөлжүүт”-ийн 600 МВт хүчин чадалтай цахилгаан станцын үйлдвэрлэсэн эрчим хүчийг говь, зүүн бүсийн хэрэглэгчдэд хүргэх боломжийг бүрдүүлнэ.

Мөн Багануур дэд станцын 220 кВ-ын хуваарилах байгууламжийг иж бүрнээр өргөтгөж, 21 ячейктэй болгох ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ нь “Багануур–Чингис–Чойбалсан”, “Багануур–Ухаа–

Улаанбаатар” зэрэг бүс нутгийг холбох ирээдүйн төслүүдийн холболтын суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

Төслийг Дэлхийн банкны хөнгөлөлттэй хөгжлийн зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогоор тендерийн бичиг баримт боловсруулах шатанд явж байна.

Хоёр. “Мандалговь–Арвайхээр чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 287 км урттай ЦДАШ, 220/110/35 кВ-ын 2х125 МВА “Өвөрхангай” дэд станц барих, 220/110/35 кВ-ын “Мандал” дэд станцыг өргөтгөх төсөл

11 аймгийн цахилгаан хангамжийг хоёр талт тэжээлтэй болгох томоохон төсөл эхэллээ.

Монгол Улсын төвийн бүсийн эрчим хүчний аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах зорилготой “Мандалговь–Арвайхээр” чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ) болон шинэ дэд станцын бүтээн байгуулалт албан ёсоор эхэллээ.

Нэгталын тэжээлээс хоёрталт хангамжруу Одоогийн байдлаар Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Хөвсгөл, Завхан, Төв, Говь-Алтай, Сэлэнгэ, Дундговь, Өмнөговь аймгийн нийт 150 сум, суурин

газар нь зөвхөн “Булган-А/Б” 110 кВ-ын ЦДАШ-аар нэг талын тэжээлтэйгээр цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна. Энэхүү шугамын ачаалал 125 хувьд хүрч, ойрын жилүүдэд 150 хувьд хүрэх эрсдэлтэй байгаа нь системийн найдвартай байдалд ноцтой аюул учруулж буй.

Төслийн хүрээнд:

220 кВ-ын 2 хэлхээт, 287 км урттай ЦДАШ, 220/110/35 кВ-ын 2х125 МВА хүчин чадалтай “Өвөрхангай” дэд станц болон “Мандал” дэд станцын өргөтгөл хийгдэхээр төлөвлөгджээ.

Эдгээр бүтээн байгуулалтаар 11 аймгийн 154,430 хэрэглэгч хоёр талын тэжээлтэй болж, байгалийн болон технологийн саатлаас үүдэх эрчим хүчний тасалдал эрс буурна.

Төсөл хэрэгжсэнээр Нийслэл хотыг Орхоны хөндийд шилжүүлэн хотын хүн амын төвлөрлийг бууруулах Хархорум хотыг барих бүтээн байгуулалт, 10 аймгийн дулааны станц, Жижиг, дунд үйлдвэрлэл, Аялал жуулчлал зэрэг үндэсний хэмжээний томоохон төслүүдийг цахилгаанаар хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН БУЛАН

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн эцэг, эхийн салбар зөвлөлүүд 2025 оны туршид хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, ажилтнуудынхаа гэр бүлийн оролцоог дэмжих чиглэлээр олон талт, үр дүнтэй үйл ажиллагаа зохион байгууллаа.

Гүйцэтгэх захирлын 2025 дөрөвдүгээр сарын 30-ны өдрийн А/72 дугаар тушаалаар компанийн болон төв удирдлагын эцэг, эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, бүтэц, чиг үүргийг тодорхойлсон. Үүний үр дүнд компанийн хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж, 2025–2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө ч мөн батлагдсан юм.

Хүүхдийн баярт сэтгэл шингэсэн хөтөлбөрүүд

“Хүүхдийн эрхийг хамгаалах” өдрийг тохиолдуулан салбар зөвлөлүүд Үйлдвэрчний эвлэлийн хороонуудтай хамтран ажилтнуудынхаа хүүхдүүдэд зориулсан баярын арга хэмжээг

салбар бүртээ зохион байгуулсан. Төв удирдлагын эцэг, эхийн зөвлөл “Захидал бичээрэй” арга хэмжээг санаачлан, хүүхдүүдийн илгээсэн сэтгэл шингэсэн захидлуудыг эцэг эх, ах эгч нарт нь уншиж өгч, хариу талархлын захидлаар хүүхдүүддээ хүргэсэн нь онцгой дурсамж үлдээсэн юм.

Танхимын сургалтууд: Гэр бүл, харилцаа, хүмүүжил

Төв удирдлагын эцэг, эхийн зөвлөл нь Хан-Уул дүүргийн гэр бүл, хүүхэд хамгааллын хэлтэстэй хамтран дараах танхимын сургалтуудыг зохион байгууллаа: “Хувь хүний хөгжил” — 2025.05.20

“Хосын харилцаа” — 2025.05.27

“Хүүхэд хүмүүжлийн аргууд” — 2025.06.10

уг сургалтууд нь ажилтнуудын дунд эерэг хандлага, ойлголцлыг бий болгоход чиглэсэн байв.

САЛБАРУУДАД ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ ХҮРЧ АЖИЛЛАХ НЬ

Зүүн-Өмнөд бүсийн салбар нь “Гэр бүл хөгжлийн төв”-тэй хамтран “Гэр бүлийн эерэг харилцаа”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” сэдвээр танхим болон цахим сургалт зохион байгуулсан бол Төвийн бүсийн салбар нь 14–16 насны хүүхдүүдэд зориулсан “Мэргэжил бүхэн сайхан” арга хэмжээг 2025 есдүгээр сарын 26-нд зохион байгуулж, 25 хүүхдийг ажлын байртай танилцуулсан нь хүүхдүүдийн ирээдүйн сонголтод эерэг нөлөө үзүүлсэн.

Мэдээ бэлтгэсэн: Захиргаа удирдлагын хэлтсийн хүний нөөцийн мэргэжилтэн Б.Солонго

ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР 94 ЗӨРЧИЛ ИЛРЭВ

ХАБЭА-н чиглэлээр батлагдсан удирдамжийн дагуу салбарын харьяа 18 дэд станц 3 албанд ХАБЭА-н III шатны үзлэгийг салбарын удирдлага, ҮЭХ, ХАБЭА хариуцсан бүрэлдэхүүн газар дээр нь ажиллаж хагас жилийн байдлаар 94 зөрчил илрүүлснээс 64 зөрчлийг устгасан байна. Арилгасан зөрчлийн дийлэнх нь дасгал, зааварчилгаа дутуу, журналын бичиглэл хангалтгүй, ажлын байрны эмх цэгцгүй байдал байлаа. Өмнөх шалгалтаар илрүүлсэн зөрчил 80,3% буурсан үзүүлэлттэй байна.

Энэ үеэр Салбарын дарга Э.Равжаадэлгэрэх салбарын харьяа дэд станцуудын ажлын байртай бүрэн танилцаж



ажилтнуудын санал сэтгэгдлийг сонсож салбарт хийгдэж байгаа ажил хэтийн бодлогыг танилцуулсан нь онцлог байлаа.

98 АЖЛЫН БАЙРАНД ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛЭЭ

Компанийн хэмжээнд ISO 45001 ХЭМАБ-ийн менежментийн тогтолцоо нэвтрүүлсэнтэй холбоотой салбарын 98 ажлын байранд эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийж баталгаажуулсан. Эрсдэлийн үнэлгээг ажилтан бүрийн ажлын байрны онцлог, ажлын байрны тодорхойлолтын дагуу гаргаж баталгаажуулсан байна. үнэлгээний үр дүн ажлын байрны онцлогоос хамаарч Бага эрсдэлтэй гарсан ба эрсдэлийн төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ИННОВАЦЛАГ БОЛОН БҮТЭЭЛЧ АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

KFW төсөл, шинэчлэлийн ажил Төвийн бүсийн салбарын 13 дэд станцад хийгдэхээр байгаагаас 2025 оны байдлаар 110/35/6 кВ Сүхбаатар, 110/35/6 кВ Хөтөл, 110/35/10 кВ Баясгалант, 110/35/6 кВ Бугант, 110/6 кВ Шарын гол, 110/10 кВ Баруунхараа 6 дэд станцад тоноглолын шинэчлэлийн ажлууд үе шаттай хийгдэж ажлын явц 70%-тай байна.

1.110/6 кВ Шарын гол дэд станцад:



110 кВ-ын ХТ-2, Т-2-н 110 кВ-ын ОД, КЗ-ын анхдагч болон хоёрдогч хэлхээний кабелийг тайлж сүвлэх, Т-2-ын 110 кВ-ын ОД, КЗ болон бетон сууриудыг буулгаж, шинээр суурилуулах салгуур, таслуурын суурийн нүхийг ухах таслуурын хөрсний тэгшилгээ нягтруулга хийж, суурийн бетон цутгах ажлууд хийгдэж байна.

2. 110/6 кВ Бугант дэд станц: Т-1, 2-н 110 кВ-н ОД, КЗ-г буулгаж 110 кВ-н ЭТ, гүйдлийн трансформатор солих ажил 100% хийгдэж салбарын комисс хүлээж авав.

3. 10/35/10 кВ Баясгалант дэд станц: 35кВ-ын СХТ, Хайлааст, Өгөөмөр, Тосон АШ-н Таслуур, гүйдлийн тр-ыг шинээр сольж

суурилуулах, Т-1, Т2-н 110/35 кВ-н таслуур, ГТ-ыг буулгаж ЭТ, ГТ шинээр суурилуулах анхдагч болон хоёрдогч хэлхээний холболт монтажийн ажил бүрэн хийгдэж салбарын комисс хүлээж авав.

4. 110/35/6кВ-н Хөтөл дэд станц: 2025 оны зургаадугаар сарын 17-ноос 2025 оны наймдугаар сарын 28-ний хугацаанд хийгдэв. Төслийн ажлын хүрээнд Хөтөл дэд станцын Т1,2-ын 110/35кВ-ын таслуур, ГТ, 35кВ-ын насос А, Б карьер Агаарын шугамуудын таслуур, ГТ-ууд суурилуулж анхдагч болон хоёрдогч хэлхээний холболтыг бүрэн хийж дуусаж ашиглалтад орууллаа.

Мэдээ бэлтгэсэн: Компьютер техник хангамжийн инженер Н.Оюунболд

ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ҮНДСЭН АЖЛЫН ХҮРЭЭНД

- 110 кВ-н Мөрөн агаарын шугамын утас арматурыг засварлах, бохирдсон элемент солих их засварын ажлыг 2025 оны наймдугаар сарын 21-25-ны өдөр хүртэл Ч.Анхдаваагаар ахлуулсан 19 хүний бүрэлдэхүүнтэй бригад 4 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн.



- 110 кВ-н Хархорин-А, Б цахилгаан дамжуулах агаарын шугамын утасны габарит багатай Т№783, 785, 787-д СК-22 маркийн тулгуурыг СК-26 маркийн тулгуураар сольж габарид бариулах ажлыг 2025 оны наймдугаар сарын 10-ны өдөр Ч.Анхдаваагаар ахлуулсан 21 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн.



- 110 кВ-н Хялганат-А, Б цахилгаан дамжуулах агаарын шугамын 5400ш тусгаарлагч элемент солих ажлыг 2025 оны наймдугаар сарын 18-21-ний өдрүүдэд Ч.Анхдаваагаар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн.

- 220 кВ-н 201, 202 цахилгаан дамжуулах агаарын шугамын голын эрэг дээр байрлалтай Т№401-д суурийн хүчитгэл хийх, голын урсцыг өөрчлөх, далан хийх ажлыг 2025 оны гуравдугаар сарын 21-ны өдрөөс дөрөвдүгээр сарын 4-ний өдрүүдэд Д.Болдбаатараар ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй далан босгож, голын урсац өөрчлөх ажлыг хийж гүйцэтгэсэн.

- 110/35/10 кВ-ын Хишиг-Өндөр дэд станцын 10 кВ-ын КРУН шинэчлэх ТЗБАХ-ний ажлын тендерт "Шинэ зууны эрдэнэт" ХХК шалгарч 2025 оны зургаадугаар сарын 07-оос наймдугаар сарын 05-ны өдрийн дотор хийж гүйцэтгэн барилгын ажлыг хүлээж авах техникийн комисс ажиллаж үүрэг даалгавар өгсөн. Гүйцэтгэгчийн зүгээс комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хийхээр ажиллаж байна.



ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРКЫН ГАДНА ЦАХИЛГААН ХАНГАМЖ, БАГЦ-1

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Үйлдвэр технологийн паркийн гадна цахилгаан хангамжийн ажлыг нийт 3 багц болгон ажиллаж байна.

Үүнээс 1-р багц буюу шинээр 220/110/35 кВ-ын Оюут дэд станц барих ажлын гүйцэтгэгчээр "Саруул өргөө констракшн" ХХК шалгарсан. Одоогоор дэд станцын талбай бэлдэх газар шорооны ажил бүрэн дуусаж 220 кВ-ын тоноглолуудын суурийн ажил 40%, 110 кВ-ын тоноглолуудын суурийн ажил 13%-ийн гүйцэтгэлтэй байна.

ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРКЫН ГАДНА ЦАХИЛГААН ХАНГАМЖ, БАГЦ-2

Багц-2 буюу 220 кВ-ын Оюут-А, Б цахилгаан дамжуулах агаарын шугам барих, Эрдэнэт дэд станцын өргөтгөлийн ажлын гүйцэтгэгчээр "Цагаан хорол" ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.



Одоогоор 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажил бүрэн дуусаж, Эрдэнэт дэд станцын өргөтгөлийн суурийн ажил эхлээд явж байна.

ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ

Уг төслийн гүйцэтгэгчээр MCS ХХК шалгарч 2025 оны наймдугаар сарын 03-13-ны өдрийн хооронд 110/10 кВ-ын Хялганат дэд станцын Т-1, 2-ын 110 кВ-ын ВМТ

таслуурын элегаз таслуураар солих ажлыг хийж гүйцэтгэсэн. Дараагийн дэд станц болох 110/35/10 кВ-ын Хархорин дэд станц дээр зарим материалууд буусан байна.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Салбарын хэмжээнд харьяа 12 дэд станц, 4 алба, 2 хэсэгт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн I, II улирлын III шатны үзлэгийг тухай бүрд зохион байгуулж үзлэгээр нийт 204 зөрчил илрүүлж, 179



зөрчлийг устгасан.

Дээрх зөрчлүүд дийлэнх хувийг журнал бүртгэл болон ажлын байрны эмх цэгц, нэр хаягтай холбоотой зөрчлүүд эзэлж байна. Мөн 4 зөрчлийг устгахад шаардлагатай материал, хэрэгслийг 2026 оны төлөвлөгөөнд тусгахаар шийдвэрлэсэн байна.



Мэдээ бэлтгэсэн: Холбооны инженер Э.Батням

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Улаанбаатар салбарын 220 кВ-ын 416км 11ширхэг ЦДАШ, 110 кВ-ын 504км 43 ширхэг ЦДАШ, 35 кВ-ын 3 ширхэг 7,5 км ЦДАШ-ын нийт 928 км цахилгаан дамжуулах агаарын шугамын координатын цэг тодорхойлох ажил хийгдэж дууслаа.

Мөн салбарын 34 дэд станцаас өөрийн эзэмшил газартай 31 дэд станцын координатын цэг тодорхойлох ажил хийгдээд байна.

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

- Их засварын 36 нэр төрлийн ажил хийж гүйцэтгэхээс 25 ажил хийж дуусгаж гүйцэтгэл 69.4%

- Урсгал засварын ажил 41 нэр төрлийн ажил хийж гүйцэтгэхээс 36 нэр төрлийн ажил хийж 87.8% гүйцэтгэлтэй байна.

- ТЗБАХ-4 нэр төрлийн ажил хийж гүйцэтгэхээс 1 нэр төрлийн ажил хийж

гүйцэтгэсэн. Гүйцэтгэл 25%,

- ХО-ын 9 нэр төрлийн худалдан авалт хийхээс 1 нэр төрлийн худалдан авалт хийгдэж. Гүйцэтгэл 11,1%-тай байна.

ИХ ЗАСВАРЫН АЖЛААР

1. Сонгино дэд станцын 220 кВ-ын 47, 110 кВ-н 55, 35 кВ-н 14, нийт 116 нэр төрлийн салгуурт их засварын ажил хийж гүйцэтгэсэн байна.

2. Хөшигт дэд станцын контор газардуулгын эсэргүүцэл 2.2 Ом норм хангаагүй тул эсэргүүцэл бууруулах их засварын ажил хийж гүйцэтгэсэн.

3. 119 дүгээр агаарын шугамын тулгуур №1-101 хооронд нийт уртын дагуу их засварын ажил хийж гүйцэтгэсэн.

4. 120-р агаарын шугамын тулгуур №1-138 хооронд уртын дагуу, дамжуулагч утасны габарит барихгүй, чангалах боломжгүй тул тулгуур №40, 73, 84, 90-г ПШ26-7 маркийн төмөр бетон тулгуураар сольж хүчитгэх их

засварын ажил хийж гүйцэтгэсэн.

5. 203, 204 дүгээр агаарын шугамын тулгуур №95-124 хооронд нийт 30 ширхэг тулгуур будах их засварын ажил хийж гүйцэтгэсэн.



АВААР УСТГАХ АЖЛААР

1. Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас 131, 132-р агаарын шугамын тулгуур №61 гулзайсан, тулгуур №62, 75, 76, 77, 78 унасан аваар устгах ажлаар дөрөв хоногийн хугацаанд У110-2+5 маркийн анкер тулгуур нэг ширхэг, ПБ110-8 маркийн төмөр бетон тулгуур таван ширхэгийг угсарч

Мэдээ бэлтгэсэн: Инженерийн албаны ахлах бөгөөд ашиглалтын инженер Б.Нарантуяа

УЛААНБААТАР САЛБАР ӨРГӨТГӨЛ БАРИЛГА АШИГЛАЛТАД ОРЛОО.

Улаанбаатар салбарын өргөтгөлийн барилгын нээлтийн үйл ажиллагаа 2025 оны наймдугаар сарын 21-ний өдөр зохион байгуулав. Нээлтэд компанийн удирдлага, ахмадын хороо, хэлтэс, салбар, Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга, гүйцэтгэгч компанийн төлөөлөл оролцов.



ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

- Баянмөнх дэд станц Т-1 110 кВ-н трансформатор;

- 110 кВ-н Өндөрхаан агаарын шугамын хэзгий тулгуур тэгшлэх, үерийн эрсдэлтэй тулгуурт намгийн хамгаалалт, татуурга хийх ажил;

ТЗБАХ-ний ажлуудаас дараах ажлууд хийгдэж гүйцэтгэл гарсан.

- 143-р цахилгаан дамжуулах агаарын шугамын намаг устай, цэгт байрласан тулгуур №403-427-р хооронд агаарын шугамын трасс өөрчилж эрсдэл бууруулах, техникийн арга хэмжээ авах.

- 110/35/10 кВ-н Сайншанд дэд станцад Т-1,2 110/35 кВ-н ЦШ шинэчлэх

- Олон үйлдэлт шитний хэмжүүр шинээр суурилуулах /SATIC/

ГЭРЭЭТ АЖЛЫН ХҮРЭЭНД

Монголын Газрын тос боловсруулах үйлдвэрийн захиалга “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК гэрээт ажлаар Сүхбаатар аймагт баригдаж байгаа Газрын тос дамжуулах хоолойн Өргөх, халаах станц-2 тэжээл болох 54.3 км 110

Мэдээ бэлтгэсэн: Мэдээлэл технологи, компьютерын инженер Б.Пүрэвсүрэн

ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

Сүлжээ” ТӨХК нь “М Си Эс Интернэйшнл” ХХК-тай гэрээ байгуулан 24,9 км урт агаарын шугамын барилга угсралтын ажлыг 2024 оны аравдугаар сарын 20-ний өдрөөс эхлэн, 2025 оны дөрөвдүгээр сарын 27-ны өдрийн хооронд нийт 17 машин механизм, 42 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэн дуусгасан.

Мөн техникийн комиссоос өгөгдсөн үүрэг даалгавар буюу шилэн кабель бүхий аянгын троссод оруулга хийх, хэзгий тулгуур тэгшлэх зэрэг ажлуудыг 2025 оны зургаадугаар сарын 05-13-ны өдрүүдэд гүйцэтгэж бүрэн хүлээлгэн өгсөн юм.

215:216-р агаарын шугамын уртын дагуу тулгууруудад боолтын чангалгаа, 98 ширхэг завсрын тулгуурт үл буцах гайк хийх,

мөн Чойр - Мандалговь чиглэлийн 225-р агаарын шугамын 2 ширхэг СК-26 завсрын тулгуур солих, тулгууруудын газардуулгын эсэргүүцэл хэмжих ИЗА-уудыг нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй засварын бригад хийж гүйцэтгэсэн. Уг ажлаар:

-215:216-р АШ-н Т№ 24-өөс Т№ 140-ийн хооронд үл буцах гайк

-225-р АШ-н цууралттай Т№ 449, 686-ийг тус бүр солих

-225-р АШ-н тулгуурын газардуулгын эсэргүүцэл нь тогтоогдсон норм хэмжээнээс өндөр гарсан 25 тулгуурын газардуулгын эсэргүүцлийг бууруулах

-Газардуулга нь ил гарсан тулгууруудын, газардуулгыг булаах ажлууд хийгдсэн.

ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ЭНГЭРИЙН КАМЕР АШИГЛАЖ ЭХЭЛЛЭЭ

2023 оны дөрөвдүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 220/110/35 кВ-ын Мандал дэд

кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил 2024-2025 он дамнан гүйцэтгэсэн.

2025 оны наймдугаар сарын 01-25-ны өдрүүдэд Засварын албаны дарга Г.Болдхуяг ИА-ны засварын инженер Г.Алтангэрэл нараар ахлуулсан 32 хүний бүрэлдэхүүнтэй бригад дутуу байсан АН27-АН1 хооронд 4 ширхэг анкер босгох, 22 ширхэг завсрын тулгуур босгож дамжуулагч утас татах 165 тулгуурын газардуулах хийх, 15 цэгт аянгын тросны залгаа, бэхэлгээ хийх ажлуудыг амжилттай хийж дуусгасан байна.

СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

2025 оны зургаадугаар сарын 24-ний өдөр “Хүний аюулгүй байдлын академи”-тай хамтран нийт ажилтнуудад зориулсан ХАБЭА-н сургалтыг батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулав. Тус сургалтад салбарын хэмжээнд нийт 134 ажилтан хамрагдаж, 13 ажилтанд сертификат олгосон байна.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

2025 оны 2 дугаар улирлын ХАБЭА-н үзлэг, аюулгүй ажиллагааны, галын аюулгүй байдлыг хангах 12 үзүүлэлтээр алба, хэсэг, дэд станцуудад хяналт шалгалт зургаадугаар сарын 03-18-ны өдрүүдэд хийв. Салбарын хэмжээнд 92 зөрчил илэрсэн бөгөөд өмнөх үзлэгээр илэрсэн зөрчлөөс 3.2%-иар буурсан үзүүлэлттэй байсан.

Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө тоо	Гүйцэтгэл тоо	Гүйцэтгэлийн хувь
Их засвар	9	8	88%
ТЗБАХ	9	4	44%
Хөрөнгө оруулалт	8	4	50%
Урсгал засвар	39	39	100%
Гэмтэл устгал		16	
Нийт дүн	65	71	

ХАБЭА-н үзлэг, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан ажлын гүйцэтгэлийг шалгахад салбарын хэмжээнд 89.2% -ийн гүйцэтгэлтэй гарч тайланг салбарын

удирдлагуудад танилцуулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

Салбарын алба, хэсэг, дэд станцуудад улирал бүр зохион байгуулах бүх төрлийн дасгалын төлөвлөгөөний дагуу нийт ажилтнуудыг тухай бүр хамруулан ажилласан ба аваар эсэргүүцэх дасгал 16 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 262 ажилтан, галын аюулаас урьдчилан сэргийлэх дасгал 16 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 262 ажилтан, осол эсэргүүцэх, анхны тусламж үзүүлэх дасгал 15 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор 282 ажилтан тус тус хамрагдсан байна.

ЗАСВАРЫН АЖЛЫН ТАЛААР:

Их засварын хийгдсэн ажлуудаас дурдвал:

- 143-р цахилгаан дамжуулах агаарын шугам-ын дамжуулагч утас хэсэгчлэн солих, /PLP/ ГВН тавих;

- 110 кВ-н Айраг агаарын шугамын 16 ширхэг анкер зэврэлтээс хамгаалж будах;

- Айраг, Сайншанд дэд станцад боловсон ариун цэврийн өрөөтэй болгох;

ойлголт чиглүүлэх сургалтыг, мөн “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай дагалдах гэрээ”, “Албан томилолтын журам” гэх сэдвүүдийн хүрээнд сургалт, мэдээлэл хүргэж ажилласан.

ТӨЛӨВЛӨГӨӨТ ЗАСВАРЫН МЭДЭЭЛЭЛ

2025 оны батлагдсан төлөвлөгөөт засварын ажлууд доорх гүйцэтгэлтэй хийгдэж байна. Үүнд:

-Их засварын ажлаар нийт 10 нэр төрлийн ажил төлөвлөгдсөнөөс 7 ажил бүрэн хийгдсэн, ажлын гүйцэтгэл 70%-тай

-ТЗБАХ-ний ажлаар нийт 3 нэр төрлийн ажил төлөвлөгдсөнөөс 1 ажил бүрэн хийгдсэн, ажлын гүйцэтгэл 33%-тай

-Хөрөнгө оруулалтаар нийт 11 нэр төрлийн ажил төлөвлөгдсөнөөс 3 ажил бүрэн хийгдсэн, ажлын гүйцэтгэл 27%-тай

-Урсгал засварын ажлаар нийт 50 нэр төрлийн ажил төлөвлөснөөс 49 ажил бүрэн хийгдсэн, ажлын гүйцэтгэл 98%-тай

“Нарийн Сухайт - Баян Хөндий 110 кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамын, 2х16 МВа дэд станцын төсөл”-н ажлыг “М Си Эс Интернэйшнл” ХХК гүйцэтгэж байна. Тус ажилд “Цахилгаан Дамжуулах Үндэсний

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА” АВЧ ДҮГНЭЛТ ГАРГАЛАА

Ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн ажлын хүрээнд 2025 оны 08 дугаар сард “Сэтгэл ханамжийн судалгаа” авч дүгнэлт гаргалаа.

Тус судалгаанд нийт 64 ажилтан хамрагдаж санаа бодлоо ирүүлсэнтэй холбоотой цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан нийт ажилтнуудын 95.2% нь байгууллага, ажил мэргэжлээрээ бахархдаг гэв.

Ажилтнуудын сэтгэл ханамжид нөлөөлдөг чухал хүчин зүйлсийн нэг нь байгууллагын нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд байдаг. Иймд байгууллагын нэр хүнд нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх нь тухайн байгууллагад ажиллаж буй ажилтнуудын үүрэг юм.

“ДАТА УДИРДЛАГЫН ДАШБОАРДЫН СИСТЕМ”

Инженерийн алба болон Санхүү эдийн засгийн албанаас салбарын нийт ажилтнуудын дунд танхимын болон цахим хосолсон хэлбэрээр “Дата удирдлагын дашбоардын систем” түүний талаарх



“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО

ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТИЙН ХҮРЭЭ

Монгол Улсын эрчим хүчний шилжилтийн үйл явцыг дэмжих зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)-өөс үндэсний онцлогт нийцсэн Тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээ (JETF)-г боловсруулахдаа эрчим хүчний салбарын үйлдвэрчний эвлэл, ажилтнуудын дуу хоолой, санал бодлыг тусгах үүднээс МЭХГУУ-н Үйлдвэрчний эвлэлийн холбооны эрчим хүчний салбарын гишүүн байгууллагуудын гишүүдтэй зөвлөлдөх уулзалтыг 2025 оны есдүгээр сарын 11-12-нд зохион байгууллаа. Уулзалт IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх Л.Цэлмэгсайхан “Тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээ боловсруулах” төслийн талаар, эрчим хүчний зөвлөх О.Бавуудорж “Тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн өнөөгийн нөхцөл”-ийн талаар танилцуулсан юм.

Оролцогчид дөрвөн багт хуваагдан

Эрчим хүчний шилжилтийн сорилт, боломж, шийдлүүдийн талаар зөвлөлдөж, санал санаачилга гаргасан нь Тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн хүрээ (JETF)-г боловсруулахад чухал хувь нэмэр болсон талаар төслийн удирдагчид онцлон дурдав. Тус хэлэлцүүлэгт “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн Улаанбаатар салбарын ашиглалтын инженер Э.Бүрэнжаргал, Г. Өсөхбаяр, ээлжийн инженер Ч. Мандхай, ИХБ-3 ээлжийн инженер Оюунтуяа мөн компанийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга Ц.Мөнхбаатар нар оролцож өөрийн компанид тулгамдаж байгаа асуудлаар санал бодлоо хэлж идэвхтэй оролцлоо.

Япон улсын Цахилгаан эрчим хүчний үндэсний ҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч Мория Мибү Компанийн үйл ажиллагаатай танилцлаа.

МЭХГУУ-н үйлдвэрчний эвлэлийн холбооны урилгаар Монгол Улсад айлчилж буй Япон улсын Цахилгаан эрчим хүчний



үндэсний ҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч Мория Мибү тэргүүтэй төлөөлөгчид Монгол улсад айлчилсан. Айлчлалын хүрээнд 2025 оны наймдугаар сарын 25-нд “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, компанийн техник технологи, ажилчдын нөхцөл байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, боловсон хүчин, бүтээмжийн зэрэг асуудлаар мэдээлэл солилцлоо.

Уулзалтын үеэр талууд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт, хүний нөөцийн бодлого, ажилтнуудын эрх ашгийг хамгаалах чиглэлээр туршлага хуваалцаж, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар ярилцсан байна.

КОМПАНИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРОО-ООС УЛААНБААТАР САЛБАРЫН ШИНЭ ӨРГӨТГӨЛ БАЙРАНД УХААЛАГ САМБАР ДУРСГАВ.

Улаанбаатар салбарын өргөтгөлийн шинэ байр ашиглалтад орж 2025 оны наймдугаар сарын 21-нд нээлтийн арга хэмжээ болсон юм.

Компанийн үйлдвэрчний эвлэлийн хорооны зүгээс тус салбарт 86 инч ухаалаг самбар бэлэглэж байгааг илэрхийлж, хорооны дарга Ц.Мөнхбаатар хүлээлгэн өгсөн байна.

ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ДАРГААР Ц.МӨНХБААТАР СОНГОГДЛОО.



Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны ээлжит хурал 2026 оны 01 дүгээр сарын 09-нд болж, хорооны удирдлагын сонгууль явагдав.

Хуралдаанд компанийн 7 салбарыг төлөөлсөн 102 төлөөлөгч оролцож одоогийн дарга Ц.Мөнхбаатар, Улаанбаатар салбарын ээлжийн инженер А.Гэмгүй, ашиглалтын инженер Г.Өсөхбаяр, ээлжийн инженер Т.Энхтайван нар нэр дэвшин саналын дүнгээр 60.8 хувийн саналаар Ц.Мөнхбаатар дарга улиран сонгогдлоо.

Ээлжит хурлаар мөн бусад зөвлөл, хорооны төлөөлөгчид сонгогдсон байна. Эмэгтэйчүүдийн зөвлөлийн төлөөлөгчөөр 54 хувийн саналаар А.Гэмгүй, Залуучуудын зөвлөлийн төлөөлөгчөөр СХТХ-ийн өгөгдлийн шинжилгээ, оновчлолын инженер Б.Золбаяр, Хяналтын зөвлөлийн даргаар Улаанбаатар салбарын үндсэн хөрөнгийн нягтлан З.Мөнхнасан, гишүүдээр диспетчер инженер Р.Алдаржавхлан, ашиглалтын инженер О.Золбуян нар томилогдон ажиллахаар болжээ.



“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ЗАХИРГАА, ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН 2025-2026 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭГ ЦУВРАЛ БОЛГОН ХҮРГЭХ НЬ

ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛЛЫН ТАЛААР

2.1 Компанийн ажилтны сарын дундаж цалин хөлсийг ажилтны үндсэн цалин, эрчим хүчний салбарт ажилласны удаан жилийн нэмэгдэл, албан ажлын онцгой нөхцөлийн, мэргэшлийн зэргийн, сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдлээс тооцно.

2.2 Захиргаа нь хөдөлмөрийн харилцаа, нормчлол, цалин хөлсний асуудлаар Үйлдвэрчний эвлэлийн хороотой зөвшилцөж байна. Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт (тариф)-ын хэлэлцээрийн 3.1 дүгээр заалтын нэмэлт өөрчлөлтийг баримтлан ажилтнуудын албан тушаалын үндсэн болон тарифт цалинг дунджаар 10-15 буюу түүнээс дээш хувиар нэмэгдүүлэхээр тооцож, цалингийн шатлал, сүлжээг боловсронгуй болгох ажлыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ. Цаашид цахилгаан эрчим хүчний дамжуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифын өөрчлөлтөөс хамаарч цалинг салбарын Хамтын хэлэлцээрийн 3.3 дахь заалтад тусгагдсан адил түвшний компаниудын хэмжээнд хүргэхээр зорино. 2026 оны цалин хөлсний нэмэгдлийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор хийгдэх салбарын нэмэлт хэлэлцээрийг үндэслэн тохиролцоно. Компанийн цалингийн сан болон албан тушаалын үндсэн ба тарифт цалинг нэмэгдүүлэх асуудлыг захиргаа, ҮЭ-ийн хороо хамтран шийдвэрлэнэ.

2.3 Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хорооноос

тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 1.6 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байх бөгөөд 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 1.7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

2.4 Компанийн тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, ажлын үр дүн, санхүүгийн ашиг, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан 3 ба түүнээс дээш сарын албан тушаалын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний санг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтооно. Ажилтны жилийн ажлын үр дүнг харгалзан 5 хүртэлх сарын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тогтоосон санд багтаан олгож болно.

2.5 Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д болон албан тушаалын цалингийн жишиг, тарифын шатлал сүлжээ, цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсний тухай журамд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулахад Үйлдвэрчний эвлэлийн хорооны саналыг авч, биелэлтэд нь Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран хяналт тавина.

2.6 Ажилтанд цалин хөлсийг сар бүрийн 10, 25-ны өдөр олгох бөгөөд ээлжийн амралтын цалинг амралт эдлэхээс өмнө олгоно. Цалин хөлс олгох өдөр нь долоо хоног бүрийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарвал өмнөх ажлын өдөрт шилжүүлнэ.

2.7 Тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжээр ажилласан ажилтны шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг бодож олгоход

дундаж цалин хөлсийг 1.35 дахин буюу 35 хувиар нэмэгдүүлэн олгоно.

2.8 Өдрийн 8 цагаар ажилладаг ажилтныг илүү цагаар ажиллуулсан тохиолдолд нөхөн амруулаагүй бол нийтээр амрах баярын өдөрт ажилласан цагт ногдох нэмэгдэл хөлсийг түүний дундаж цалин хөлснөөс 2 дахин, бусад өдөрт ажилласан нэмэгдэл хөлсийг түүний дундаж цалин хөлснөөс 1.5 дахин нэмэгдүүлэн олгоно. Ээлжийн графикаар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтанд тухайн сард нийтээр амрах баярын өдөрт ажилласан цагт ногдох нэмэгдэл хөлсийг түүний дундаж цалин хөлснөөс 2 дахин, бусад өдөрт ажилласан нэмэгдэл хөлсийг түүний дундаж цалин хөлснөөс 1.5 дахин нэмэгдүүлэн олгоно.

2.9 Сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг, тухайн сарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагаа, үр ашиг, эрчим хүчний хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, үр дүнд үндэслэн тухайн хамт олон (хэлтэс, алба, хэсэг)-ы албан тушаалын болон тарифт цалингийн 50 хүртэл хувиар бодож олгоно. Сарын болон жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журмыг компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан мөрдөнө.

2.10 Компанийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор ажлын өндөржүүлсэн байдал тогтоон илүү цагаар ажиллуулахдаа Үйлдвэрчний эвлэлийн хороотой урьдчилан зөвшилцөж байна.

2.11 Эрх бүхий байгууллагын гэрчилгээ, батламжийг үндэслэн Шинжлэх ухааны доктор

зэрэгтэй ажилтанд албан тушаалын цалингийн 40 хувь, PhD зэрэгтэй ажилтанд 30 хувиар, зөвлөх зэрэгтэй инженер, тэргүүлэх зэрэгтэй төсөвчинд албан тушаалын цалингийн 20 хувиар, мэргэшсэн инженер, мэргэшсэн нягтлан бодогч, эдийн засагч, мэргэшсэн төсөвчинд 15 хувийн нэмэгдлийг бүтээлийн тайлан, холбогдох журмыг үндэслэн үндсэн цалингаас нь бодож олгоно. Нэмэгдэл олгох ажлын байрны жагсаалтыг гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, тухайн ажлын байрны тодорхойлолтод тусгаж хэрэгжүүлнэ. Нэг хүнд нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

2.12 Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж, мэргэжлийн өндөр үр чадвар гаргаж байгаа ажилтанд үр чадварын нэмэгдлийг албан тушаалын үндсэн ба тарифт цалингийн 30 хувиар олгоно.

2.13 Ажил мэргэжил хослон, орлон, хавсран ажилласны нэмэгдлийг хослон, орлон, хавсран ажилласан албан тушаалын үндсэн ба тарифт цалингийн 40 хувиар олгоно. Харин удирдах ажилтан хяналтад байдаг ажил, албан тушаалыг орлон ажиллахыг хориглох бөгөөд уг заалтад хамаарах ажлын байр, албан тушаалын ангиллыг журмаар зохицуулна. Ээлжийн амралттай, нэг сараас доош хугацаанд өвчтэй, чөлөөтэй байгаа ажилтны ажил үүргийг хослон, түр орлон, хавсран гүйцэтгэсэн тохиолдолд энэхүү нэмэгдлийг олгохгүй.

Мэдээ бэлтгэсэн: Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга Ц.Мөнхбаатар

Мэндчилгээ

Ахмад настны баярыг тэмдэглэх шийдвэрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1990 онд гаргасан бөгөөд Монгол Улс 1992 оноос эхлэн жил бүрийн аравдугаар сарын 1-ний өдөр ахмад буурлууддаа хүндэтгэл үзүүлж, баярын арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн билээ.

Энэ түүхэн өдрийг тохиолдуулан “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн нийт ахмад ажилтан, өндөр настанд хөдөлмөр зүтгэлийнх нь үр шимийг хүндэтгэн, бие сэтгэлийн амар амгалан, эрүүл энх, урт удаан наслахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлэе. Монгол Улсын үндэсний цахилгаан дамжуулах сүлжээний суурийг 1960-аад онд тавьж, 1970, 1980, 1990-ээд оны сорилт бэрхшээлийг бүтээлч шийдэл, шургуу хөдөлмөрөөр даван туулж, 2000-аад оны хөгжил дэвшлийн эрчийг манлайлан нэгэн жарны түүхийг хамтдаа бүтээлцсэн та бүхний алдар гавьяагаар бид бахархдаг.

Төвлөрсөн цахилгаан хангамжийн хүрээг тэлж, хуучирсан тоног төхөөрөмжийг шинэчлэн, ашиглалт үйлчилгээг хөнгөвчилж, “Наушки-аас Замын-Үүд, Баруун-Уртаас Баянхонгор” хүртэлх өргөн уудам нутагт цахилгаан эрчим хүчийг найдвартай түгээж, улс орны хөгжил, ард иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан түүхийн гэрч нь та бүхэн билээ. “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн хөгжлийн түүхийг улам баяжуулахын тулд таны болон хамт олны хөдөлмөр, бүтээл, техникийн дэвшил, арга туршлага, амжилт, сургамж, дурсамжийг илтгэх гэрэл зураг, сонин хэвлэл, радио, телевизийн сурвалжлага, дурдатгал, ном зэрэг баримт материалыг харьяаллын нэгжид ирүүлнэ гэдэгт гүнээ итгэж байна. Нэгэн жарны түүхийг хамтдаа бүтээлцсэн та бүхэнд гүн талархал илэрхийлэе.

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн алдар түүх улам арвижих болтугай

Хүндэтгэсэн, Ахмадын хороо

УЛААНБААТАР САЛБАРЫН АХМАДЫН ХОРОО

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн Улаанбаатар салбарын даргын 2023 оны хоёрдугаар сарын 17-ны өдрийн А/08 дугаар тушаалаар салбарын ахмадын хороог байгуулж, даргаар нь ахмад настан С.Оюунцэцэгийг томилон ажиллаж байна. 2025 оны байдлаар ахмадын зөвлөл нь үндсэн 10 гишүүн, нийт 119 ахмад настантай үйл ажиллагаа явуулж байна.



Ахмад настан Ш.Хандсүрэнд хүндэтгэл үзүүлж байгаа нь /2023 он/

2025 онд 1 ахмад настан төрийн дээд шагнал Алтангадас одонгоор, 2 ахмад настан Засгийн газрын шагнал “Эрчим хүчний тэргүүний ажилтан” тэмдгээр шагнагдсан.

Тус салбар компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-ний хүрээнд ахмад настануудын дунд сар шинийн баяр, олон улсын ахмадын өдрөөр хүндэтгэл үзүүлж, халаалтын улирлын хөнгөлөлтийг жилд нэг удаа олгож байна. Тухайлбал, 2024 онд 103 ахмад настанд халаалтын улирлын хөнгөлөлт 10,300,000 төгрөг, 2025 онд Монголын уламжлалт цагаан сарын баярыг тохиолдуулан 115 ахмад настанд 8,130,000 төгрөг, 107 ахмад настанд эрчим хүчний тэргүүний болон бусад салбарын тэргүүний ажилтны нэмэгдэл 9,630,000 төгрөг, 8 ахмад настанд насны ойг тохиолдуулан 1,400,000 төгрөгийн мөнгөн тэтгэмж тус тус олгосон байна.

Улаанбаатар салбарын Ахмадын хорооноос 70-85 насны гэртээ асаргаанд байгаа



2025 оны аравдугаар сарын 03-ны өдөр ахмадуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлээ.

Мэдээ бэлтгэсэн: Ахмадын хорооны дарга Л.Дарамбазар

6 ахмад настны ар гэрт нь очиж, хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулсан.

Төвийн бүсийн салбарын АХМАДЫН ХОРОО

Төвийн бүсийн салбарын ахмадын зөвлөл нь нийт 81 ахмад ажилтантай. Зөвлөлийн үйл ажиллагааг 5 тэргүүлэгч гишүүн удирдан зохион байгуулж салбарын захиргаа болон

ҮЭХ-той хамтран ажилладаг.

Тус ахмадын зөвлөл нь Дархан Сэлэнгийн бүс нутагт Эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 60 жилийн түүхийг хамтдаа бичилцэж явсан ахмадууд мөн Аж үйлдвэрийн гавьяат хоёр байна.

Манай ахмад ажилтнууд нь: Дархан хотод 47, Зүүнхараа Борнуур сумуудад 19, Сүхбаатар, Бугант, Ерөө сумуудад 10, Шарынгол, Сайхан /Хөтөл/, Орхон сумдуудад 5 ажилтан орших суудаг.

Тус салбарын зохион байгуулж байгаа нийгмийн болон үндсэн үйл ажиллагааны ажилд санал зөвлөмж өгөх тусалж дэмжих ажилд идэвх зүтгэлтэй хувь нэмрээ оруулан хамтран ажиллаж ирсэн.

Хамтын ажиллагааг товч дурдвал:

1. Салбараас ахмад настан ажилтнуудаа хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, тэтгэмж тэтгэлэг зэргийг цаг хугацаанд олгож,

2. Салбарын захиргаа бидний санал санаачилгыг дэмжин Салбарын болон Компанийн спортын арга хэмжээнд ахмад тамирчдаа оролцуулах, Орон нутгийн эрчим хүчний салбарын ахмад ажилтнуудын уралдаан тэмцээнд дэмжиж оролцуулахад санал санаачилгатай ажилладаг.

3. Ахмадын зөвлөл нь салбарын ажилтнуудын дархлааг дэмжих зорилгоор салбарын цайны газарт амин дэм ихтэй жимс чацаргана 20кг, аарц 5кг, сахар 10кг-г хандивлан ажилласан.

4. Салбарын захиргаа нь ахмадын зөвлөлд шинээр баригдах лаборатори, туршилтын барилгад ахмадын өрөөг тохижуулж өгөхөөр ажиллаж байгаад ахмадууд таатай хүлээн авч байна.

6. Ахмад ажилтан бидэнд байнга дэмжиж хамтран ажилладагт “Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК, Төвийн бүсийн салбарынхаа хамт олонд Дамжуулах сонинороо дамжуулан баярлаж талархлаа илэрхийлэхийн ялдамд та бүхний ажилд өндөр амжилт, эрүүл энхийг хүсэн ерөөе.

ХАНГАЙН БҮСИЙН САЛБАРЫН АХМАДЫН ХОРОО

Хангайн бүсийн салбарын ахмадын зөвлөл нь нийт 103 ахмадтай үйл ажиллагаагаа явуулж хорооны даргаар

Ё.Ариунаа, тэргүүлэгч гишүүдээр Ц.Ганболд, Д.Дашням, Ц.Амгаланбаатар нар ажиллаж байна. Салбарын нийт ахмадуудын 31,4% нь 71-ээс дээш насны өндөр настнууд байдаг бөгөөд хамгийн өндөр настай ахмад

91 настай Д.Чанцал юм.

Салбарын ахмадын хорооны нэгдсэн хуримтлалын санд Эрдэнэтийн төвийн хэсгийн болон Мөрөн, Цэцэрлэг, Баянтээг, Булган, Хархорин, Тосонцэнгэл дэд станцуудын нийт 42 ахмадууд хамрагддаг бөгөөд эхний 9 сарын байдлаар хуримтлалын сангаас шагнал урамшуулалд -300,0 мян, эмчилгээний зардал болон сэтгэлийн хандивт-550,0 мян, бусад арга хэмжээнд 810,0 мян. төг-ийг тус тус зарцуулсан байна.

ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАРЫН АХМАДЫН ХОРОО

Салбарын ахмадын зөвлөл нь 2012 онд байгуулагдаж 13 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Хорооны даргаар Д.Амгаланбаатар 2024 оноос сонгогдон ажиллаж 4 тэргүүлэгчтэй 57 гишүүнтэй.

Салбарын ахмад ажилтнуудын холбогдолтой хууль тогтоомж, хамтын гэрээ, ахмад настны асрамж, халамж, амралт сувиллын чиглэлээр төрөл бүрийн хөнгөлөлтөд хамруулах, байгууллага, иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, ахмадуудын амьдралын нөхцөл байдлыг судалж байнгын анхаарал тавих, тэдний ажил, амьдралын арвин туршлагыг залуу хойч үеийнхэнд өвлүүлэх, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэх зарим чиг үүргийг аймаг, нийслэл, сум, баг, дүүрэг, дүүргүүдийн хороо, аж ахуйн нэгж байгууллагуудын ахмадын хороо, зөвлөлдүүдтэй хамтран ажиллах ажиллаж байна.

Мөн салбар ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд конторын 2 давхарт засварын ажлын зардлыг гарган өрөө тохижуулж, ахмадын зөвлөлд хүлээлгэн өгсөн.





СУРГАЛТЫН БУЛАН

ОХУ-ЫН НОВОСИБИРСК ХОТЫН ПК БРИЗ КОМПАНИД АРМ СР3А-5 ПРОГРАММ ХАНГАМЖИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАВ.

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-иас РХАХТХ-ийн тооцооны инженер Б.Тунгалагсайхан, ДҮТ ТӨХХК-ны инженерүүдийн хамт 2025 оны зургаадугаар сарын 30-аас долоодугаар сарын 09-ний өдрүүдэд ОХУ-ын Новосибирск хот дахь “ПК БРИЗ” компанид зохион байгуулагдсан АРМ СР3А-5 программ хангамжийн мэргэжлийн сургалтад амжилттай хамрагдлаа.

Тус сургалтаар

- Цахилгаан сүлжээний мэдээллийг хөрвүүлэн оруулах, сүлжээний орлуулгын схемийн график редакторын онцлог шинж чанарыг судлах

- Программ дээр ЭХС-д холбогдсон цахилгаан станцууд, ЦДАШ-уудын загварчлал болон тэдгээрийн схем холболтын график дүрслэл, сүлжээний математик загвартай ажиллах хүснэгтэн интерфэйс үүсгэн сүлжээний график загварт шилжүүлэх боломж

- Зэрэгцээ шугамуудын нөлөөллийн утгыг тооцоололд оруулан ашиглах нөхцөл

- Цахилгаан тоноглолын өгөгдлийг бусад форматад хөрвүүлэн ашиглах боломж

- Программ хангамж дээрх хэрэглээний цэсүүдийн онцлог, үйл ажиллагаа

- Богино залгааны тооцооллыг гүйцэтгэх модулийг судлах

- АРМ-СР3А программ хангамжийн үндсэн цэсүүдийн нэг болох ТКЗ /Ток короткого замыкания – Богино залгааны гүйдлийн утга/-ын үйл ажиллагааны онцлогийг судалж, ЭХС-д үүсэж болох гэмтлийн нөхцөл байдал, шинж чанарыг тооцоололд хэрхэн оруулах талаар

- Реле хамгаалалтын тавилын тооцооны модулийг судлах

- Программ хангамж дээр цахилгаан тоноглолын бэлтгэл хамгаалалтуудын /ДЗ, ТЗНП, МФТЗ/ тавилын тооцоог системийн максимум, минимум горимын үед тооцооллыг хийх

- Программ хангамж дээр микропроцессорын релений онцлогт тулгуурлан /SIEMENS, SEL/ бэлтгэл хамгаалалтын тавилын өгөгдлийг оруулан тооцооллыг хэрхэн хийх талаар тус тус судалсан.

Энэхүү сургалт нь оролцогч инженерүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, АРМ СР3А-5 программ хангамжийг оновчтой ашиглах мэдлэг, туршлагыг олгосон чухал алхам боллоо.



СУРГАЛТ БҮТЭЭМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

“Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ” ТӨХК-ийн Сургалт бүтээмж, хамтын ажиллагааны хэлтэс нь компанийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг бодлого, төлөвлөгөөний дагуу тасралтгүй дээшлүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Мөн бүтээмжийн арга хэрэгслүүдийг компанийн хэмжээнд нэвтрүүлж, ажилтнуудын бүтээмжийн ухамсрыг төлөвшүүлэх замаар дараах үр дүнд хүрэхийг зорьж байна.

- Ажлын байрны эмх цэгц, аюулгүй байдал, эрүүл ахуйн таатай орчин бүрдүүлэх

- Хөдөлмөрийн сахилга бат, ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх

- Ажлын чанар, үр дүнг тасралтгүй сайжруулах

Багаар ажиллах чадварыг төлөвшүүлэх

Гадаад болон дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан туршлага солилцох боломжийг нэмэгдүүлэх.

Хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд компанийн зүгээс салбарын байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, сургалт, туршлага солилцох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа нь ажилтнуудын мэдлэг, ур чадварыг

өргөжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Сургалт бүтээмж, хамтын ажиллагааны хэлтэс нь 2025 оны 02 дугаар сард байгуулагдаж, компанийн хэмжээнд гадаадын 22 нэр төрлийн сургалтад 68 ажилтан 99 сая төгрөгөөр, дотоодын 45 нэр төрлийн сургалтад 110.5 сая төгрөгөөр 2530 ажилтанг хамруулж, гүйцэтгэлд хяналт тавин, салбарын сургалт, бүтээмжийн инженерүүдийг удирдлага, арга зүйгээр ханган ажилласан.

Эдгээр үйл ажиллагаа нь компанийн тогтвортой хөгжил, ажилтнуудын мэргэжлийн өсөлт, бүтээмжийн соёлыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.



ХҮЧНИЙ ТРАНСФОРМАТОРЫН ҮЙЛДВЭРИЙН ТУРШИЛТ ХИЙГДЛЭЭ.



Шинэ Зуунмод хотын 110 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, 110/35/10 кВ Сэргэлэн дэд станцын 40 МВА чадалтай хүчний трансформаторын үйлдвэрийн туршилт амжилттай хийгдлээ.

БНХАУ-ын Нанчанг хот дахь PEOPLE ELECTRIC APPLIANCE GROUP CHINA байгууллагаар үйлдвэрлүүлж буй хүчний трансформаторын туршилтыг хянах, баталгаажуулах зорилгоор “Засвар зохицуулалтын хэлтэс”-ийн Хүчний трансформаторын засварын инженер Д.Баттулга, “Судалгаа хөгжил төлөвлөлтийн хэлтэс”-ийн Байр зүйн төлөвлөлтийн инженер Л.Оюунномин нар тус компанид ажиллав.

Туршилтын хүрээнд дараах хэмжилт, туршилтуудыг хийсэн байна.

- Ороомгийн эсэргүүцлийн хэмжилт
- Фазын дараалал шалгах
- Ороомгийн холболтын бүлэг шалгах
- Тусгаарлагчийн эсэргүүцэл ба цахилгаан бат бөх чанарыг шалгах
- Богино залгааны туршилт
- Тосны түвшин, чанар шалгах
- Ачаалалгүй үеийн гүйдэл ба алдагдлын хэмжилт
- Дуу чимээний түвшин хэмжих
- Өндөр хүчдэлийн иж бүрэн туршилт

PEOPLE ELECTRIC APPLIANCE GROUP CHINA нь China People's Holding Group-ийн охин компани бөгөөд Хятадын “Топ 500 аж ахуйн нэгж”, “Топ 500 машин үйлдвэрлэлийн аж ахуйн нэгж”-ийн тоонд олон жил дараалан багтаж, Үндэсний чанарын шагнал болон Хятадын чанарын шагналын нэр дэвшигчээр шалгарч байсан туршлагатай байгууллага юм. Тус компанийн бүтээгдэхүүнүүд дэлхийн 125 гаруй улс, бүс нутагт борлуулдаг бөгөөд Зүүн Ази, Ойрхи Дорнод, Хойд Америк, Европын Холбооны орнуудад 50 гаруй салбартай.

ХУУЛИЙН БУЛАН

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИАС ...

42.2. Ажилтан дараах үндсэн үүрэгтэй:

42.2.1. ажил үүргээ биечлэн, үнэнчээр, өөрийн ур чадвар, боломжоо дайчлан зохих ёсоор гүйцэтгэх;

42.2.2. хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг дагаж мөрдөх, ажлын цагийг баримтлах, ажлын цагийг гагцхүү ажил үүргээ гүйцэтгэхэд зарцуулах;

42.2.3. ажилдаа ирэхдээ ажил үүргээ гүйцэтгэх чадвартай байх, ажил үүрэг гүйцэтгэх явцдаа согтууруулах ундаа болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхгүй байх, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхгүй байх;

42.2.4. ажил олгогч тусгайлан зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний эрхэлж байгаа үйл ажиллагаатай шууд өрсөлдсөн, давхацсан аливаа ажил, үйлчилгээ эрхлэхгүй байх;

42.2.5. техник, технологийн горим баримтлах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн чиглэлээр ажил олгогчоос өгсөн үүрэг даалгаврыг мөрдөж ажиллах;

42.2.6. өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, ажил олгогчийн эд хөрөнгөд аюултай нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажил олгогч, шууд харьяалагдах удирдах албан тушаалтанд нэн даруй мэдээлэх;

42.2.7. ажил олгогчийн удирдах чиг үүргээ хэрэгжүүлэх эрхэд хүндэтгэлтэй хандах, ажил олгогч, ажил олгогчийн төлөөлөгчийн хууль ёсны үүрэг даалгаврыг цаг тухайд нь бүрэн биелүүлэх;

42.2.8. ажил үүргээ гүйцэтгэх явцад байгууллага, хувь хүний нууц, ажил олгогчийн бизнестэй холбоотой

мэдээллийг олж мэдсэн, түүнтэй танилцсан бол задруулахгүй байх;

42.2.9. ажил олгогчийн шаардсанаар ажил үүрэгтэйгээ холбоотой мэдээллийг ажил олгогчид үнэн зөвөөр өгөх, хийсэн ажлаа тайлагнах;

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИАС ...

18.2. Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан дараахь нийтлэг үүрэгтэй байна:

18.2.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх;

18.2.2. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, хуульд тусгайлан заасан бол шалгалт өгсөн, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх;

18.2.3. хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах;

18.2.4. эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох;

18.2.5. ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;

18.2.6. ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх;

18.2.7. өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;

18.2.8. ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах.

Мэдээ бэлтгэсэн: Хуулийн зөвлөх Г.Алтангэрэл
Эрхлэн гаргасан: Сургалт бүтээмж, хамтын ажиллагааны хэлтсийн
Хэвлэл мэдээллийн мэргэжилтэн Б.Энхсанаа